



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-16
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	17-66
1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2026.03.09-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	
	18-19
2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	
	19-20
3.Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	
	20-22
4.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 202511.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	
	22-23
5.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	
	23-35 56-60
6.“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоол /“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	
	35-36 60-61
7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	
	36-55 61-62
8.“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/	
	63
9.Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох	
	63-64
10.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал	
	64-66

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
4 дүгээр сарын 10-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 74 гишүүн хүрэлцэн ирж, 58.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 01 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ч.Анар, Б.Бат-Эрдэнэ, Да.Цогтбаатар;
Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа, Ж.Ганбаатар, Х.Ганхуяг, Л.Мөнхбаатар,
Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн;
Тасалсан: Х.Баттулга, Ц.Туваан.

Хоцорсон: Ж.Алдаржавхлан-08 минут, О.Алтангэрэл-57 минут, С.Амарсайхан-36 минут, О.Амгаланбаатар-17 минут, Т.Аубакир-32 минут, Ц.Баатархүү-03 минут, М.Бадамсүрэн-06 минут, Ж.Батсуурь-33 минут, Б.Батцэцэг-45 минут, П.Батчимэг-29 минут, Э.Батшугар-10 минут, Ж.Бат-Эрдэнэ-01 минут, Ж.Баярмаа-01 минут, Ш.Бямбасүрэн-28 минут, А.Ганбаатар-54 минут, Д.Ганбат-17 минут, П.Ганзориг-02 минут, Т.Доржханд-27 минут, Б.Дэлгэрсайхан-2 цаг 10 минут, Б.Жавхлан-05 минут, Б.Жаргалан-02 минут, Ц.Мөнхбат-2 цаг 20 минут, П.Мөнхтулга-16 минут, П.Наранбаяр-42 минут, Н.Номтойбаяр-1 цаг 00 минут, Б.Пунсалмаа-1 цаг 02 минут, Д.Пүрэвдаваа-23 минут, П.Сайнзориг-04 минут, О.Саранчулуун-23 минут, М.Сарнай-23 минут, Р.Сэддорж-16 минут, Б.Түвшин-40 минут, А.Ундраа-54 минут, Ч.Ундрэм-02 минут, Г.Уянгахишиг-05 минут, Г.Хосбаяр-2 цаг 20 минут, Д.Цогтбаатар-1 цаг 49 минут, Ө.Шижир-24 минут, Ж.Энхбаяр-12 минут, С.Эрдэнэбат-43 минут, Р.Эрдэнэбүрэн-33 минут.

Нэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхийлөгч 2026.03.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Х.Тэмүүжин Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн

хэлэлцэх эсэх асуудлаас авсан завсарлагын хугацааг ажлын 1 өдрөөр сунгаж байгаа тухай мэдэгдэж, Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт уг асуудлаар ажлын 1 өдрийн завсарлага өгөв./10:09/

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн У.Отгонбаяр нарын 8 гишүүн 2025.07.09-ний өдөр өргөн мэдүүлсэн, **анхны хэлэлцүүлэг, үргэлжилнэ/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ч.Батбямба нар байлцав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, У.Отгонбаяр нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “2026 оны 5 дугаар сарын 10-ны” гэж өөрчлөх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 33
Бүгд: 86

61.6 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Бямбацогт: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, У.Отгонбаяр нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн “тавин хувь” гэснийг “гучин хувь” гэж өөрчлөх гэсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 84
Бүгд: 87

3.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 37
Бүгд: 88
58.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Хадгаламж зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 33
Бүгд: 89
62.9 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 34
Бүгд: 89
61.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 31
Бүгд: 91
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 30
Бүгд: 91
67.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 32
Бүгд: 91
64.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Санхүүгийн хоршооны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 17 гишүүн 2025.11.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, зөвлөх Ц.Баянмөнх нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 51
Татгалзсан: 40
Бүгд: 91
56.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөрийг дэмжсэнээр тооцож, 57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 56
Татгалзсан: 35
Бүгд: 91
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 53
Татгалзсан: 38
Бүгд: 91
58.2 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 52
Татгалзсан: 40
Бүгд: 92
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай нарын 21 гишүүн 2025.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Эрчим хүчний яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Х.Бекболат, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтуяа, Б.Мөнхсоёл, А.Ариунзаяа, С.Зулпхар, М.Мандхай, С.Эрдэнэбат нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлан, Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, мөн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:11/

Зургаа.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Улсын Их Хурлын 1999 оны 27 дугаар тогтоолд нэмэлт оруулах тогтоолын төслийг Засгийн газар 2026.03.19-ний өдөр яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Г.Дамдинням, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Ч.Хишигдалай, Гаалийн ерөнхий газрын Татвар, орлогын газрын дарга С.Баярмаа, мөн газрын Барааны ангиллын хэлтсийн дарга Ч.Чимгэрэл

нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./11:17/

Долоо.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Бат-Эрдэнэ нар 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Урьболд, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татварын удирдлага, олон улсын татварын газрын дарга Д.Сайханчулуун, Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам, мөн газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Ё.Энхсайхан нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин, Б.Уянга, С.Одонтуяа, М.Ганхүлэг, О.Саранчулуун нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Б.Буяннэмэх, Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгт нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./12:21/

Үдээс өмнөх хуралдаан 2 цаг 20 минут үргэлжилж, 12 цаг 21 минутад өндөрлөв.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 00 минутад тав дахь асуудал буюу Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийн санал хураалтаар үргэлжлэв.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал:

С.Бямбацогт: 1.Ж.Алдаржавхлан, Р.Батболд, Н.Батсүмбэрэл, Ж.Баярмаа, Ц.Даваасүрэн, Б.Заяабал, З.Мэндсайхан, Б.Пунсалмаа, П.Сайнзориг, Г.Хосбаяр, Д.Энхтуяа /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Хуулийн зорилт” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, тус зүйлийн өмнө “НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ” гэсэн агуулгатай **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “аюулгүй байдлыг хангах” гэсний дараа “бодлогын хүрээнд хэрэгжих” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “санхүүжилтийн ашиглалтыг” гэснийг “гадаад зээллэгийн ашиглалтыг” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59

Татгалзсан: 55

Бүгд: 114

51.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, С.Эрдэнэбат, Ч.Номин, О.Саранчулуун, Х.Баасанжаргал, Э.Болормаа, Д.Бум-Очир, Д.Цогтбаатар, Д.Энхтүвшин, Л.Энхнасан, Г.Хосбаяр, П.Батчимэг, Ж.Баярмаа нарыг дэмжсэнд тооцож, 63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан, импортыг орлох, нийгэм, эдийн засгийн ач холбогдол, үр ашиг бүхий, үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой, нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, автозамын түгжрэлийг бууруулах энэ хуульд заасан” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 45

Бүгд: 114

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 2 дугаар зүйлд “**Хуулийн үйлчлэх хүрээ**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “болон гадаад зээллэгийн эх үүсвэрийн урд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагатай холбогдсон харилцааг” гэж тус тус нэмж, мөн зүйлийн “зээллэгийн санхүүжилтийн ашиглалт” гэснийг “зээллэгийн ашиглалт” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 42

Бүгд: 114

63.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенг дэмжсэнээр тооцож, 64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг “2.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төсөл.” гэсэн агуулгатай 3.3 дахь хэсгийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 48

Татгалзсан: 66

Бүгд: 114

42.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

5.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“2.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 78

Татгалзсан: 36

Бүгд: 114

68.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг “3 дугаар зүйл” болгож, тус зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын зардал**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ГАДААД ЗЭЭЛЛЭГИЙН АШИГЛАЛТ, НЭГДСЭН ТӨСӨВ ХООРОНДЫН ХАМААРАЛ**” гэсэн агуулгатай **ХОЁРДУГААР БҮЛЭГ**-ийн нэр тус тус нэмж, мөн зүйлийн “нийт зарлага” гэснийг “нийт зарлагын дээд хэмжээ” гэж, “санхүүжилтийн ашиглалтын зардал, түүний зардлын өсөлтөөр” гэснийг “тухайн жилийн ашиглалтын зардлын өсөлтөөр” гэж тус тус өөрчилж, “Тухайн жилийн” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 72

Татгалзсан: 42

Бүгд: 114

63.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 45

Бүгд: 114

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 6 дугаар зүйлийг “3.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “гадаад зээлийн санхүүжилтийн” гэснийг “гадаад зээллэгийн” гэж өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 45

Бүгд: 114

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 7 дугаар зүйлийг “3.3” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “энэ хуулийн 3.3-т заасан” гэснийг “гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлж байгаа” гэж өөрчилж, мөн зүйлийн “хэсэг” гэсний дараа “болон энэ хуулийн 3.1-д заасан хязгаар” гэж нэмж, “санхүүжилтийн” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 43

Бүгд: 114

62.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн дугаарыг “4” гэж өөрчилж, мөн зүйлд “**Гадаад зээллэгийн ашиглалтын ил тод байдал, хяналт**” гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнө “**ХЯНАЛТ, ИЛ ТОД БАЙДАЛ**” гэсэн агуулгатай **ГУРАВДУГААР БҮЛЭГ**-ийн нэр, мөн зүйлийн “тухайн жилийн” гэсний дараа “нэгдсэн” гэж тус тус нэмж, “хагас жил тутам” гэснийг хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69

Татгалзсан: 45

Бүгд: 114

60.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийг “4.2” дахь хэсэг болгож, мөн зүйлийн “төслийн ашиглалттай” гэснийг “зээллэгийн ашиглалттай” гэж, “журмын” гэснийг “хууль тогтоомжийн” гэж тус тус өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 74

Татгалзсан: 40

Бүгд: 114

64.9 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд доор дурдсан агуулгатай бүлэг нэмэх:

“ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл.Хуулийг дагаж мөрдөх журам

5.1.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээл, тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтад 2026 оны төсвийн жилд санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан үйлчлэлд хамруулна.

5.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн гадаад зээллэгийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө.” гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 43

Бүгд: 114

62.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төсөлд шинээр нэмэх 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

“5.4.Дунд хугацаанд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хөгжлийн түнш орнуудын санхүүжилтээр хэрэгжих, төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой, эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл, арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж болох бөгөөд төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар өрийн баталгаа гаргаж болно.” гэсэн саналыг хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгч, санал хураалт явуулаагүй болно.

14.Ажлын хэсгийн гаргасан, Хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёололтой уялдуулан төслийн зүйл, хэсэг, заалтын дугаарыг болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71

Татгалзсан: 43

Бүгд: 114
62.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Найруулгын санал:

С.Бямбацогт: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “зориулан эрх зүйн таатай орчныг” гэснийг “зориулсан эрх зүйн орчныг” гэж, “зорилго” гэснийг “зорилт” гэж, 2 дугаар зүйлийн “Энэ хуулиар гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн” гэснийг “Энэ хуулийн 2.2-т заасан гадаад зээллэгийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн” гэж, “зохицуулах ба энд зааснаас” гэснийг “энэ хуулиар зохицуулах ба энэ хуульд зааснаас” гэж, төслийн 4 дүгээр зүйлийн “үл хамаарна” гэснийг “хамаарахгүй” гэж, төслийн 7 дугаар зүйлийн “санхүүжих зардал” гэснийг “санхүүжүүлэх зарлага” гэж, “нөхцөлд” гэснийг “тохиолдолд” гэж тус тус өөрчилж, төслийн 4 дүгээр зүйлийн “төслийн” гэснийг өмнөх болон 6 дугаар зүйлийн “нийт” гэснийг тус тус хасах гэсэн Төсвийн байнгын хорооны дэмжсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 47
Бүгд: 114
58.8 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа дахь асуудал буюу “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67
Татгалзсан: 47
Бүгд: 114
58.8 хувийн саналаар Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Б.Пүрэвдорж, С.Цэнгүүн нарыг дэмжсэнээр тооцож, 61.4 хувийн саналаар батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.

Долоо дахь асуудал буюу Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудал санал хураалтаар үргэлжлэв.

С.Бямбацогт: 1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 68
Татгалзсан: 46
Бүгд: 114
59.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн:

С.Бямбацогт: 2.Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57
Татгалзсан: 57
Бүгд: 114
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70
Татгалзсан: 44
Бүгд: 114
61.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Бямбацогт: 2.Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 60
Бүгд: 114
47.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул “Хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./14.34/

С.Бямбацогт: 3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57

Татгалзсан: 57
Бүгд: 114
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул “Хууль санаачлагчид нь буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов./14.36/

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 37 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 40 гишүүн 2025.10.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, үргэлжилнэ/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн завсарлагын хугацаа дууссан тухай танилцуулав.

С.Бямбацогт: “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 71
Бүгд: 114
37.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Ес. Баталсан тогтоолын эцсийн найруулга сонсох

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт дараах тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав.

Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:48/

2.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2026 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:49/

3.“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн

найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./14:49/

Арав.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга П.Батбаатар, Хуулийн газрын дарга Х.Сүрэнхорол, Байнгын хороодын асуудал эрхлэх газрын дарга Ж.Бямбадулам нар байлцав.

Улсын Их Хурлын дарга С.Бямбацогт “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./14:51/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 10 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчид, Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшингийн урилгаар Завхан аймгийн Нөмрөг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1994 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж, Цагаанчулуут багийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл, Г.Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн алдарт эхийн одонтой ээжүүдийн төлөөлөл, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын сургуулийн 8^г ангийн багш сурагчид, Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжингийн урилгаар Төв аймгийн Борнуур сумын иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 3 цаг 12 минут үргэлжилж, 126 гишүүнээс 115 гишүүн хүрэлцэн ирж, 91.3 хувийн ирцтэйгээр 14 цаг 52 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 10 цаг 01 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Бямбацогт: 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Баасан гарагийн хурал чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье ээ. Чуулганы ирц 126 гишүүнээс 71 гишүүн хүрэлцэн ирсэн байна. 56.3 хувийн ирцтэй байна тэгээд.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд ирцэд хамгийн түрүүнд манай Жадамбаагийн Баясгалан гишүүн 8 цаг 59 минутад орсон байна. Сүхбаатарын Эрдэнэболд, Дашцэрэнгийн Энхтүвшин, Бөхчулууны Пүрэвдорж, Мөнхчулууны Энхцэцэг, Батжаргалын Заяабал нарын гишүүд бас чуулганы ирцэд хамгийн түрүүлж орсон байна аа. Тэгээд эхэлж ирсэн гишүүддээ бас баяр хүргэе.

4 сарын 10-ны өдөр Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмардашийн Сарнай төрсөн байна аа. Сарнай гишүүн маань байна уу? Улсын Их Хурлын гишүүн Мягмардашийн Сарнайд төрсөн өдрийн мэнд хүргэж, Монгол төрийн эрхэм түшээ, ард түмний элч болсон Танд болон таны гэр бүлд Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар дараах 9 асуудлыг хэлэлцэнэ ээ.

1 дүгээрт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Санал хураалттай.

2 дугаарт нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Бас зарчмын зөрүүтэй 2 саналтай. Санал хураалт явагдана.

3 дугаарт нь Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэн явуулна аа. Хэлэлцэх эсэхийн санал хураалт бас явагдана энэ дээр.

4 дүгээрт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна. Санал хураалттай.

5 дугаарт нь Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

6-д Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

7-д ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгээ явуулна.

8 дугаарт Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

9 дүгээрт нь баталсан төслүүдийн эцсийн найруулгыг сонсоно оо.

Гишүүдийг чуулганы хуралдааны танхимдаа урьж байна аа. 4 сарын 8, 9-ний өдрүүдэд АН-ын Их хурал, Үндэсний бодлогын хорооны хурал болж бас өнөөдөр Монгол парламент дахь хамгийн олон суудалтай сөрөг хүчин 42 суудалтай сөрөг хүчин маань бас хуралдаанууд болж байгаа. Үүнтэй холбоотойгоор чуулганы нэгдсэн хуралдаанаар явагдах санал асуулгуудыг бас өчигдөр хойшлуулсан байгаа. Тийм болохоор өнөөдөр санал хураалтаар чуулганы хуралдаан эхэлнэ.

Одоогоос 36 жилийн тэртээ 1990 оны 4 сарын 8-ны өдөр бас Монголын шинэ цагийн улс төрийн 2 дахь хүчин анхны чөлөөт АН-ыг албан ёсоор байгуулж, анхны тугаас мандуулж байсан түүхтэй. Тэгээд эл түүхэн өдөр АН-ынхан маань Ардчиллын шинэ тэмүүлэл уриан дор 18 дугаар их хурлаа бас амжилттай зохион байгуулж байна. Бас өчигдөр, өнөөдөр бас Үндэсний бодлогын хороо нь хуралдаж байгаа юм байна аа. Тэгээд иргэд олон нийтийн дуу хоолой, ард түмний засаглал, ардчилсан нийгмийн индэр болсон Улсын Их Хурлын гишүүд АН-ын үе үеийн нийт гишүүд дэмжигч та бүхэндээ түүхэн ойн баярын мэндийг хүргэж, Үндэсний бодлогын хорооны хурал намынх нь үйл ажиллагаанд бас нийт Их Хурлынхаа гишүүдийн өмнөөс амжилт хүсье ээ.

Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдоржийн урилгаар Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын ЗДТГ-ын албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт Монгол Улсынхаа Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ. Баяр хүргэе ээ та бүхэндээ.

Хэлэлцэх асуудалдаа оръё оо.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна аа.

Төсвийн байнгын хороо юу дууссан уу?

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Бүлгээс. АН-ын бүлгээс үг хэлье гэж байх шиг байна. Завсарлах дэгтэй тийм үү? Завсарлага авахтай холбоотой үг хэлэх дэг байгаа. АН-ын бүлгийн дэд дарга Тэмүүжин. Үг өгье өө.

Х.Тэмүүжин: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая. АН-ын Үндэсний бодлогын хорооны хурал дуусаагүй. Манай гишүүдийн ирц ер нь хангалттай биш байна. Тэгээд энэ нэг талаасаа парламентыг хариуцлагажуулахтай холбоотой Ерөнхийлөгчийн өргөн барьсан хуулийг, нөгөө талаасаа парламентын дархлаа болон парламентын ардчиллыг бас эмзэг байдалд оруулах болзошгүй гэдэг бас шүүмж 2 нэлээн өрнөж байгаа. Тийм учраас гишүүдийн ирцийг сайжруулаад гишүүд биечлэн өөрсдөө оролцож энэ асуудал дээр байр сууриараа саналаа өгөх боломжийг хангах үүднээс энэ асуудал дээрээс бас АН завсарлага авч байна аа. Нэг хоногийн хугацаатай.

С.Бямбацогт: Нэг хоног оо?

Х.Тэмүүжин: Тийм. Тэгэхээр ажлын 5 өдөр болно. Ажлын 5 өдөр дотор гээд нэг хоногийн хугацаатай ирэх 7 хоногоос ирц бол гайгүй болчих байх. Тийм учраас Ерөнхийлөгчийн өргөн барьсан хуулийн гол зорилго ч гэсэн тийм байгаа шүү дээ. Гишүүд биечлэн саналаа өөрсдөө илэрхийлэх ёстой гэдэг утгаар. Тийм учраас ирцийг сайжруулах байдлаар Улсын Их Хурал өөрөө энэ дээр нэг мөсөн шийдвэр гаргах ёстой. Тийм учраас тэр боломжийг олгохын үүднээс АН завсарлага авч байна.

С.Бямбацогт: АН-ын бүлэгт нэг хоногийн завсарлага өглөө. Тэгээд 1 хоног гэдэг маань үндсэндээ 4 дэх өдрийн чуулган гэсэн үг шүү дээ тийм ээ.

Дараагийн асуудалд оръё оо.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Улсын Их Хурлын гишүүн Отгонбаяр нарын 8 гишүүн 2025 оны 7 сарын 9-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг үргэлжилнэ.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууссан. Одоо байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо.

Зарчмын зөрүүтэй 2 санал байна. Гишүүд санал хураалтад бэлдье ээ. Гишүүд санал хураалтдаа бэлдэж, 85 гишүүнээс одоогоор 46 гишүүн санал хураалтдаа бэлэн болсон байна. Бүртгэлийн санал хураалт явуулчих уу? Бүртгэлийн санал хураалт явуулъя. Ирцээ шалгаарай гишүүд. За бүртгэлийн санал хураалт.

62 гишүүн ирцэд орсон бэлэн болсон санал хураалтад эндээс 52 гишүүн санал хураалтад гарч байна. Тэгээд бусад гишүүд маань бас энэ ирцийн санал хураалт шүү бүртгэлийн. Санал хураалтдаа бэлдэж дуусаж байна уу гишүүд.

Улсын Их Хурлын гишүүн Түвшингийн урилгаар Завхан аймгийн Нөмрөг сумын ЕБС-ийн 1994 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт, амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг нийт Их Хурлынхаа гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ.

Зарчмын зөрүүтэй саналыг та бүхэндээ уншиж танилцуулъя аа.

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. ТББХ дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийн баталсан гэснийг 2026 оны 5 дугаар сарын 10-ны гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир, Отгонбаяр. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 53 дэмжсэн 53, 86 гишүүн оролцсоноос 53 гишүүн буюу 61.6 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсгийн 50 хувь гэснийг 30 хувь гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, Ухнаагийн Отгонбаяр. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 87 гишүүн оролцсоноос 3 гишүүн дэмжиж, 3.4 хувиар энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны санал, дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Санхүүгийн хоршооны хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтдаа бэлтгэж дууссан уу? Санал хураалт.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 88 гишүүн оролцсоноос 51 гишүүн буюу 58 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн ХЗХ-ны тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 89 гишүүн оролцсоноос 56 гишүүн дэмжиж, 62.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Санхүүгийн хоршооны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 89 гишүүн оролцож, 55 гишүүн буюу 61.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 60 гишүүн буюу 65.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.ЖДҮ үйлчилгээг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 61 гишүүн буюу 67.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

8.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 59 гишүүн буюу 64.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Санхүүгийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлт хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт авч, хариулт. Асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтдаа бэлдье. Санал хураалтдаа бэлдье гишүүд. 50 гишүүн бэлэн болсон байна. Гишүүд санал хураалтдаа бэлдье. За санал хураалтдаа бэлдье гишүүд. Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулья аа. Санал хураалт. Гантөмөр гишүүнийг дэмжсэнээр авъя өөр.

Ингээд санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 52 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалтад 91 гишүүн оролцсоноос 56 гишүүн буюу 61.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья.

91 гишүүн санал хураалтад оролцсоноос 53 гишүүн буюу 58.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

4. Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 92 гишүүн оролцсоноос 52 гишүүн буюу 56.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа танилцуулна аа. Таныг индэрт урьж байна аа.

Д.Үүрийнтуяа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай нарын 21 гишүүнээс 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн нэгдсэн хуралд хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 4 сарын 1, 8-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно оо.

Хуулийн төслийг Ди парламент цэг мн цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн санал авч байгаа бөгөөд төсөлтэй холбогдуулан санал ирээгүй байна. Мөн AI дүн шинжилгээний хүний эрхийн дэлгэрэнгүй тайлангаар хуулийн төслийн зохицуулах харилцаа нь эдийн засгийн эрх, хүний иргэний нийтлэг эрх, улс төрийн эрхийн зөрчилгүй гэж дүгнэсэн байна аа.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгээр хөгжлийн томоохон төслүүдийг төсвийн дүрмийн хязгаарлалтаас гадуур санхүүжүүлэх гадаад улсын туршлагын талаарх судалгааг гүйцэтгүүлж байнгын хорооны болон ажлын хэсгийн гишүүдийг мэдээллээр ханган ажиллалаа.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 74 дүгээр захирамжаар Гадаад зээллэгийн ашиглалт үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлангаар ахлуулж, Улсын Их Хурлын 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Тус ажлын хэсгээс хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр Хууль тогтоомжийн тухай

хуульд заасан хуулийн төслийн бүтцэд тавигдах шаардлагын дагуу төслийн зүйлүүдэд гарчиг өгөх. Мөн төсөлд тусгагдсан зүйлээр зохицуулж байгаа харилцааг бүлэглэх, бүлгийн нэр өгөх хуулийн төсөлд хөндөгдсөн төслүүдээс Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг хасах.

Түүнчлэн хуулийн төсөлд тусгагдсан төсөл арга хэмжээний нэрийг өөрчлөх, өөр төсөл нэмж тусгахыг хориглосон заалт болон хуулийн дагаж мөрдөх журмын зохицуулсан бүлэг нэмэх. Уг бүлэгт 2026 оны төсвийн жилийн журмыг зохицуулсан бүлэг нэмэх. Мөн уг бүлэгт 2026 оны төсвийн жилийн санхүүжилттэй холбоотой асуудлыг зохицуулах хуулийг тодорхой хугацаанд дагаж мөрдөх асуудлыг тусгаж мөн цаашид Хөгжлийн банкаар дамжуулан хөгжлийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг зохицуулсан заалт нэмэх нь зүйтэй гэж санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно оо.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Доржсүрэнгийн Үүрийнтуяа гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя аа.

Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Хөгжлийн санхүүжилт хөрөнгө оруулалтын газрын дарга, Солонгын Тулга Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Халикийн Бекболат ЭХЯ-ны ХШҮДАГ-ын дарга, Маамбын Үнэнбат НЗДТГ-ын Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга, Лхагвадоржийн Эрдэнэбадрах НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Дашдаваагийн Алтанцэцэг Монголын газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж ирцийн дарааллаараа асуулт асуудаг. Эрт ирж асуулт. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ хуулийн хуульд одоо 2, 3 төсөлд зориулж ийм хууль батлахаар орж ирсэн байгаа. Яах вэ зарчмын хувьд уул нь ингээд төслүүдэд зориулдаг биш ганц 2 төсөлд зориулсан хууль биш энэ бусад санхүүжилтийн төсвийн өөр бусад эх үүсвэрүүдээр зохицуулж байвал уул нь зүйтэй юм байгаа юм. Тэгээд энэ төслөөс 3 төсөл байсан. Газрын тосны тэгээд Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц, Сэлбэ дэд төв гээд ажлын хэсгээс Сэлбэ дэд төвийг хассантай

холбогдуулаад энэ хуулийн нэг удаагийн хуулийн нэрийг нь өөрчлөх талаар уул нь санал гаргасан юм. Өөрөөр хэлбэл газрын тос болон Эрдэнэбүрэнгийн УЦС нь зээлээр санхүүжиж байгаа Сэлбэ хасагдаж байгаа. Сэлбэ дэд төвтэй холбоотой санхүүжилт нь бол зээлийн бусад хэрэгслүүдийг ашиглаж байсан учраас энэ нэрийг нь гадаад зээллэг гэдэг байдлаар оруулсан. Тэгээд энд нь энэ төсөл нь хасагдчихсан учраас зээл гэдэг байдлаар өөрчлөх санал гаргасан боловч ажлын хэсэг дээр дэмжигдээгүй юм.

Тэгэхээр энэ одоо энэ нэртэйгээ уялдуулаад ажлын хэсэг дээр бас гарч ирсэн санал байгаа. Өөрөөр хэлбэл зээллэг гэдэг нь Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.15-аар Засгийн газрын өрийн баталгаанаас бусад өрийн хэрэгслээр дамжуулан өр үүсгэхийг зээллэг гэж хэлээд байгаа юм. Гэтэл нэрэнд нь байхгүй зүйлийг 5.4 дээр дунд хугацааны олон улсын банк санхүүгийн байгууллага болон хөгжлийн түнш орнуудын санхүүжилтээр хэрэгжих төсвийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж болох бөгөөд төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргаж болно оо гээд. Өөрөөр хэлбэл нэрэнд нь байхгүй зүйлийг энэ 5.4 дээр нэмж оруулж ирж байгаа. Тэгэхээр энийг уул нь хасуулья гээд бас ажлын хэсэг дээр чадаагүй. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд бас энийг анхаарна биз. Тэгээд энэ тал дээр яагаад ийм нэрэнд нь байхгүй зүйлийг ийм заалт оруулж ирж байгаа юм бэ? Ажлын хэсгээс энэн дээр тайлбар хэлээч?

Тэгэхээр энэ чинь хууль чинь хоорондоо зөрчилдөөд асуудал үүсэх юм биш үү. Уул нь энэ төсөл юу хуулийг нь бас хурдан явуулаад энэ төслүүдийг нь бас явуулах шаардлага байгаа байх. Гэхдээ энэ өөрөө хууль нь хоорондоо зөрчилдсөн, нэрэндээ байхгүй зүйлийг дотор нь нэмж оруулаад Сангийн яам нь болохоор ажлын хэсэг дээр асуухаар энэ манай оруулаагүй санал байна гэж байна. Тэгэхээр Сангийн яам мэдээгүй саналыг хаанаас нь хэн оруулаад, яагаад ийм зөрчилтэй санал оруулчав гэдэг талаар хариулт өгөөч?

С.Бямбацогт: Хариулья, хэн хариулах вэ? Ажлын хэсэг Алдаржавхлан ажлын хэсгийн ахлагч Жуковын Алдаржавхлан гишүүн асуултад хариулья. Ажлын хэсгийн ахлагч.

Ж.Алдаржавхлан: Энхтүвшин гишүүний асуултад хариулья. Энэ саяын асуудлаар бид нар байнгын хороон дээр бас нэлээн өргөн хэлэлцүүлэг хийсэн. Яагаад гадаад зээллэгийн гэж нэрлэсэн бэ. Яагаад гадаад зээлийн гэж нэрлээ юу гэдэг асуудал дээр манай Их Хурлын зарим гишүүд асуудал тавьсан. Манай хэрэгжих гэж байгаа 2 төсөл маань өөрөө зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа нь бол үнэн. Гэхдээ гадаад, дотоод нөхцөл байдлын нөхцөл байдал үнийн өсөлт бий болж болзошгүй байгаа учраас бид нар төслүүд дээр бас үнэт цаас гаргах, бонд гаргах нөхцөлийг ирээдүйд бүрдэж магадгүй гэж үзээд зээллэг гэдэг ерөнхий хэллэг авсан. Ингэснээрээ энэ төсөл бүрэн амжилттай хэрэгжих бололцоог нэгд бүрдүүлнэ гэж харж байгаа.

2 дугаарт тэр Хөгжлийн банкны асуудал дээр бол манай ажлын хэсгээс гишүүдээс гаргасан санал ажлын хэсгээс гаргасан санал. Энэ санал байнгын хороон дээр дэмжигдсэн. Гэхдээ биднүүс өнөөдөр Энхтүвшин гишүүний саналыг аваад эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл авъя гэсэн бодолтой байгаа.

Энэ дээр Их Хурлынхаа гишүүдийн саналыг авч дахин сайн ярилцъя гэсэн ийм бодолтой байгаа.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Гүйцээн боловсруул энэ юу 5.4 дээр тэр нэрэндээ байхгүй Засгийн газрын өрийн баталгаа гаргах зохицуулалтыг эргэж харъя гэсэнд баярлалаа. Тэгээд энэ сая юу Алдаржавхлан ажлын хэсгийн ахлагчийн ярианаас болохоор 2 төслөөс асууя. Энэ газрын тосны үйлдвэр тэгээд Эрдэнэбүрэнгийн УЦС дээр энэ зээлийн гэрээнээс гадна саяын байдлаар өрийн бусад хэрэгслүүд бонд гаргах ч гэдэг юм уу, Засгийн газрын өрийн баталгаагаар өөр санхүүжилт хийх ийм төлөвлөгөө байгаа юу? Энэ талаар төсөл тус бүрээрээ газрын тос Эрдэнэбүрэн төсөл хариуцсан хүмүүс мэдээлэл өгөөч?

С.Бямбацогт: Ажлын хэсэг Жуковын Алдаржавхлан гишүүн, тэндээс хэн хариулах юм. Дэлгэржаргал дарга хариулах уу? За Сангийн яам, 3 номерын индэр.

Ж.Дэлгэржаргал: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар Дэлгэржаргал. Эрдэнэбүрэнгийн УЦС газрын тос боловсруулах үйлдвэрийн хувьд бол Өрийн удирдлагын тухай хууль, Тогтвортой байдлын тухай хуулиар Улсын Их Хурлаар соёрхон батлагдсан гэрээ хэлэлцээртэй. Өөрөөр хэлбэл яг санхүүжилтийн эх үүсвэр нь гадаад зээлийн эх үүсвэр байгаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг гишүүдийн асуултад гүйцэд нэлээн тийм үү бодитой хариулт өгмөөр байна. Хангалттай биш учраас гишүүд олон дахин тодруулж байна шүү дээ. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Тодруулах гээд байгаа шалтгаан нь ажлын хэсгийн ахлагчийн ярьсан, Сангийн яамны ярьсан 2 зөрөөд байгаа байхгүй юу. Хэрвээ юу Сангийн яам болохоор энэ 2 төсөл бол зээлээр санхүүжүүлнэ өөр одоо асуудал байхгүй гэж байна. Гэтэл ажлын хэсгийн ахлагч маань болохоор энэ өөр санхүүгийн хэрэгслүүдээр энэ төслийг нэмж санхүүжүүлж магадгүй гэсэн ийм буруу ойлголтууд өгөөд байна. Тэгэхээр аль нь зөв юм бэ гэдгийг хагалахад аягүй хэцүү болчихоод байна л даа. Хэн нь хариулах ёстой юм. Ажлын хэсгийн ахлагч шал өөр юм өөр юм яриад байна. Сангийн яамны төсөл хариуцсан хүмүүс нь өөр юм яриад байна. Тэгэхээр яг энийг хэн нь зөв яриад байгааг бас Улсын Их Хурал дээр зөв мэдээлэл өгөөч.

С.Бямбацогт: Тийм. Их Хурлын гишүүдийн асуусан асуултад үнэн зөв бодитой хариулт мэдээлэл өгөх ёстой. Хэрвээ худлаа мэдээлэл өгөх юм бол худлаа мэдээлэл өгсөн албан тушаалтан бас хариуцлага хүлээх хуулийн заалттай шүү ажлын хэсгийн гишүүд ээ. 3 номерын микрофон. Сангийн яам Солонгын Тулга. Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын дарга

С.Тулга: Гишүүний асуултад хариулъя. 2 төслийн хувьд Энхтүвшин гишүүн ээ, энэ дээр бол яг Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр явж байгаа болохлоор энэ дээр өөр өрийн хэрэгсэл ашиглах бол шаардлагагүй байгаа. Тэнчээ орж байгаа хуулийн заалт дээр дунд хугацаандаа Засгийн газрын гадаад зээлийг авч ашиглах юм бол одоо энийг Хөгжлийн банкаар дамжуулна. Хөгжлийн банкаар дамжуулах юм бол Засгийн газрын баталгаа ашиглаж болно оо гэсэн ийм агуулгаар

хуулийн төсөл бичигдсэн юм болов уу гэж харж байгаа. Одоо бол манай гэрээ байгуулчихсан, авч ашиглаж чадаагүй байгаа Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл маань өөрөө 14 их наяд хүрчихсэн байгаа. Бид нар төсөв дээр жил болгон ашиглалтаар бол 1.5-аас 1.2 их наядын ашиглалт гарч байгаа. Тэгэхлээр цаашид ингээд гадаад зээл яг ингээд Засгийн газрын төсөв дээр тусаад ингээд явахлаар ашиглалт дээр багтахгүй ийм асуудал үүсээд байгаа учраас Хөгжлийн банкаар дамжуулъя. Тэгэхдээ гадаад зээлийн ашиглалтыг нэмэх зорилгоор Засгийн газрын баталгаа гаргая. Баталгаа гаргахлаар мэдээж...

С.Бямбацогт: Монгол хоолт хүүхдийн халамж нийгэмд үйлчлэх ТББ-ын багш, хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсье ээ. Сурлагын өндөр амжилтыг хүсье ээ.

Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуултаа асууя алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Ирцэд 102 гишүүн байна. 126-102, 81 хувьтай. Гишүүд байхгүй байгаа учраас Улсын Их Хурлын тухай хууль Ерөнхийлөгчийн өргөн барьсан хуулийг АН ирцгүй гээд хойшлуулчихаад өөрийнхөө хуулийг бол явуулчихлаа л даа. Ийм л ялгамжтай ханддаг байхгүй юу. Тэгээд иргэд энийг бас харж байгаа байлгүй. Удаан хугацаанд хүмүүсийг ингэж талцуулах, үл ойлголцол үүсгэх, хэнд ямар ашигтай юм. Одоо тэгээд Даваа гарагийн бүлгээр бас тэгээд л чиглэл өгөөд л элдэв янзын асуудал болох юм байна л даа. За юу болж байгааг тэгээд хүмүүс харж байгаа биз дээ.

Асуудалдаа оръё. Гадаад зээлийн асуудал. Би анхнаасаа энэ хуулийг бол дэмжээгүй. Яагаад гэвэл бид нар давхар төсөв үүсгэх гээд байгаа юм. Зүгээр төсөвтөө оруулаад хяналттай, тайлагналттай, ашиглалттай, цааш цаашдаа архивтай авсан зээлээ авсан шиг аваад, түүнийгээ зарцуулсан шиг зарцуулаад ингээд явах ёстой. Харамсалтай нь тэгээд алдагдалгүй төсөв гэдэг энэ хийрхлээс болж бид нар авсан зээлээ ашиглаж чадахгүй төслүүд гацаад маш хүнд нөхцөл байдалд орсон. Газрын тосны үйлдвэрийн хийж хэрэгжүүлсэн ажлуудынхаа мөнгийг нь ч өгч чадахгүй, гадаад түнштэйгээ маш хүнд нөхцөл байдалд орчихсон байгаа шүү дээ. Тэгээд юунаас болсон юм улс төржилт хийдлээс болсон байхгүй юу. Гарцыг одоо ингэж харж байгаа юм бол тэгээд энүүгээрээ л явахаас. Гэхдээ миний хувьд бол дэмжихгүй хэвээрээ л байгаа.

Шинэ Ерөнхий сайд, шинэ Сангийн сайд энэ асуудлаа уг нь илүү томоор харж асуудлаа шийдвэрлэмээр байгаа байхгүй юу. Тэгэхээр энийгээ цаашдаа бас засах, залруулах, төсвөө зөв оруулж ирэх энэ тал дээр нь Мэндсайхан сайд анхаараарай. Бид нар бүгдээрээ л энэ олон төсөвтэй байх зовлонг бол мэднэ шүү дээ. Хамтдаа энэ алдааг засах гэж бас 10, 12 жил болсон. Авсан зээлээ хийж хэрэгжүүлж байгаа энэ төслөө гацаадаг байдлыг яаж зогсоох вэ нөхөд өө. Маш их мөнгө зарцуулчихаад ажлынхаа тодорхой хэсгийг нь хийж хэрэгжүүлээд эхэлчихсэн байхад гаднын компаниудад гаднын хөрөнгө оруулалттай компаниудад амлалтаа өгөөд, гэрээгээ байгуулаад ажлуудыг нь эхлүүлчихсэн байгаад зогсоогоод байгаа асуудлыг яах вэ, хэрхэх вэ. Энэн дээр бол бас толгойгоо ажиллуулахгүй бол болохгүй нь ээ нөхөд минь. Тэгээд Улсын Их Хурлын гишүүд нь өөрсдөө бас дагаж намираад, бас дахиад улс төржөөд л энэ төсвийн үр ашиггүй зарцуулалтыг өөрсдөө ингээд биеэрээ

үлгэрлэн манлайлан яваад байх юм. Энийг бас юу гэж ойлгох вэ. Маш хариуцлагагүй байна аа нөхөд өө. Энэ дээр л анхаараасай гэж хүсье дээ. Өөр ч юу гэх вэ баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсэг хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Жуковын Алдаржавхлан асуултад хариулна.

Ж.Алдаржавхлан: Энэ хууль бол амин чухал хууль байгаа. Манай улсын төсвийн багтаамж өөрөө гадаад зээл ашиглалт дээр 1.5 их наядаас илүү бид нар зарцуулж чадахгүй байгаа, хүн болгон мэдэж байгаа. Манай улс 13.5 их наяд төгрөгийн гадаад зээл авчихсан, тэрийгээ хэрэглэж чадахгүй байгаа, хэрэглэж чадахгүй учраас өдөр тутам хүү төлж байгаа. Тийм учраас энэ хуулийн ерөөсөө зорилго бол 2 төсөв биш гадаад зээлийнхээ ашиглалтыг нэмэгдүүлье л гэж байгаа юм. Одоо авчихсан байгаа тийм. Гадаад зээлийн ашиглалтыг нэмээд явъя, төсвийн харилцаан дээр бүртгэл нь бол яг хэвээрээ явна аа гэж ойлгож болно.

С.Бямбацогт: Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуултаа асууя.

Б.Мөнхсоёл: Өглөөний мэнд. Түрүүн дээшээ гарч байх хооронд нэр дуудчихсан уучлаарай байхгүй таарчихлаа. Тэгээд гол асуудал Төсвийн байнгын хороон дээр бас яригдсан. Бид нар чуулган 2024 оны намар эхэлснээс хойш яригдаж байгаа нэг асуудал бол Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилт буюу нөгөө төсвийн гол 4 дүрмийн биелэлт байгаа. Гэтэл нөгөө талдаа энэ олон улсын байгууллагуудаас гадаадаас зээл босгочихдог. Энийгээ үр ашигтай зарцуулж чаддаггүй харин ч эсрэгээрээ үндсэн төлбөрийн болон хүүгийн төлбөрт явчих гээд. Тэгэхдээ бүртгэгдээгүй үед бол угаасаа энэ юунд ордоггүй юм байна лээ балансад. Тэгэхээр хамгийн гол асуудал юу вэ гэхээр энэ 2 талд байгаа асуудлыг бид нар түр зуурын хугацаанд буюу төслөөс төсөлд шийдэх биш ер нь үүрдийн буюу байнга тогтвортойгоор шийдэх асуудал тулгамдчихсан байгаа шүү.

Тэгэхээр энэ удаадаа 3 төсөл орж ирсэн гадаад зээлийн энэ төсөл. Энэнээс 3 төслөөс Сэлбийн төслийг нь хасаж байгаад энэ 2 төслийг нь энэ удаадаа дэмжихье гэсэн ийм асуудал яригдаж байгаа. Яагаад вэ гэхээр тухайлбал Энэтхэгийн Элчин сайд хүртэл Төсвийн тогтвортой байдлын Төсвийн байнгын хорооныхонтой уулзаад инженерүүддээ, ажилчдадаа бас цалинг нь олгож чадахгүй байна. Энэ газрын тосны үйлдвэрийн үйл ажиллагаа зогсох ийм байдал төлөвтэй байгаад байна гэдэг асуудал учир байдлаа бас ойлгуулж ярьсан байгаа.

Нөгөө талдаа бид нар бас байнга анхаарах ёстой 2 дахь том чухал асуудал юу вэ гэхээр нэгэнт ийм том том бүтээн байгуулалтын ажил мега төслүүд хэрэгжиж эхэлсэн бол гүйцэтгэл дээрээ, чанартай гүйцэтгэл дээрээ төсвийн өртөгт байдал нь нэмэгдэхгүй байх тал дээр хугацаа уртсахгүй байх тал дээр байнга анхааралтай ажиллах ёстой ийм асуудал байгаа юмаа.

Тэгэхээр миний хувьд хувь хүний зүгээс санал болгож байгаа зүйл юу вэ гэхээр угаасаа жил болгон төсөв батлах эсвэл төсөв тодотгох үед гарч ирдэг асуудал болох төсвийн сахилга бат, хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх ямар төсөв нь ТЭЗҮ-тэй байх юм, хэрхэн яаж үнэлэгдэх юм гэдэг энэ асуудлуудыг цэгцлэх зайлшгүй ийм чухал асуудал тулгамдчихсан. Тэгээд Сангийн яамнаас энэ Хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг боловсруулж байгаа. Энэ дээр дэмжиж ажиллаж байгаа. Энийг цаашдаа бас Улсын Их Хурал дээр дэмжиж

хэлэлцэх ёстой гэдгийг бас энэ ташрамд хэлчихье ээ. За баярлалаа. Асуулт биш бараг санал болчхов уу даа.

С.Бямбацогт: Санал хэллээ. Сархадын Зулпхар гишүүн асуултаа асууя.

С.Зулпхар: Улсын Их Хурлын дарга гишүүдийнхээ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ өдрүүдэд ер нь бидний хэлэлцэж байгаа хууль болгон нэг бол улс төрийн ач холбогдолтой, нэг бол эдийн засгийн ач холбогдолтой, нэг бол нэг нийгмийн ач холбогдолтой ийм хуулийн төслүүд байгаа. Тэгэхлээр гишүүд маань бас энэ хуулийн төслүүдийг шуурхай санаачилж хэлэлцүүлэхээр оруулж ирж байгаад бас талархалтай байна аа. Бид гаднаас зээл авч тэр зээлийн үр ашигтай үр дүнтэй хэрэглэж гэмээ нь улсынхаа эдийн засгийг өргөдөг цаашлаад нийгмийн томоохон асуудлуудыг шийдэх бас үндэс энүүгээр тавигддаг гэдгийг бүгд мэдэж байгаа. Тэр битгий хэл бүс нутагт сүүлийн жилүүдэд тодорхой улсууд томоохон зээл авч стратегийн ач холбогдолтой төслүүд хэрэгжүүлж байгаа. Бидний эргэн тойронд байж байгаа нэн ялангуяа ижил гараанаас гарсан Төв Азийн улсууд байгаа юм. Төв Азийн улсууд дотроо бид тухайлан нэрлэх ёстой. Казакстан, Узбекстан, Киргизстан, Тажикстан гэх мэтчилэн. Тухайлбал Тажикстан бол томоохон УЦС байгуулах замаар дотоодынхоо эрчим хүчийг хангаад зогсохгүй бүс нутагтаа эрчим хүч экспортолж байна. Эргээд энэ бол эдийн засгийн хувьд томоохон үр нөлөө өгч байгаа учраас энэ зээлийг яаж ашигладгийг бол их онцгой харуулж байна гэж байгаа юм.

40 гаран жил дайны байдалтай байсан Афганистан гэж улс сүүлийн 3 жил бидний муу хэлээд байдаг нөгөө Талибанууд улс орноо удирдаж байгаа. Мөн адил мега төсөл хэрэгжүүлэх, томоохон зээл авах, тэрийг үр ашигтай ашиглах чиглэлээр ажиллаж байна аа гэж байгаа юм. Тэгэхлээр зээл бол энэ аюултай зүйл биш ээ гэдгийг бид бас эдийн засгийн утгаар нь ойлгох ёстой. Гэхдээ зээлийг бид зөв удирдаж чадах уу, тэрийг зөв үр ашигтай ашиглаж чадах уу гэдгээс л бүх зүйл шалтгаалдаг. Тэгэхлээр энэ утгаар нь аваад үзэх юм бол Монгол Улсад хэрэгжиж байгаа томоохон мега төслүүд, стратегийн ач холбогдолтой төслүүд дээр авсан энэ зээлийг шуурхай ашиглах, үр дүнг нь хурдан үзэх зайлшгүй шаардлага байгаа юм. Бид нэг төсөл эхэлж байна гээд 10 жилийн дараа дуусах юм шиг байдлаар тэр төслийн үр дүнг хүлээснээр бол ямар нэгэн хөгжил улс оронд ирэхгүй ээ. Тэгэхээр энэ талаас нь бодож бид бас энэ хуулийн төслийг бол шуурхай жишээ нь хэлэлцээд, одоо шийдээд гаргачих ёстой гэж бодож байгаа юмаа.

Би хууль санаачлагчаас их тодорхой асуулт асууя. Энэ хууль маань гадаадын зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх, хяналттай болгох, хариуцлагатай болгох энэ тогтолцоог сайжруулах чиглэлээр ямар ямар ач холбогдлыг авчирч байгаа юм бэ гэдгийг та бүхэн бас дэлгэрэнгүй яриад өгөөч ээ. Баярлалаа.

С.Бямбацогт: Асуулт. Нөгөө анхны хэлэлцүүлэг явж байгаа болохоор Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж ажлын хэсэг, Байнгын хороо хариулах ёстой. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хариулъя.

Н.Алтаншагай: Баярлалаа. Энэ хууль маань одоо яг маш амин чухал...

С.Бямбацогт: Уучлаарай би энэ юу яачихъя. Нэг танилцуулга хийгээдэхье. Улсын Их Хурлын гишүүн Ундрамын урилгаар Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ахмадууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа.

Та бүхэндээ амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хариулъя.

Н.Алтаншагай: Баярлалаа. Зулпхар гишүүний асуултад хариулъя.

Монгол Улсын авсан зээлийн ашиглалтын хэмжээ хангалттай түвшинд батлагдахгүй байгаагаас шалтгаалж эдгээр төслүүд маань хэрэгжилт удааширч ямар нэгэн бодлогын өөрчлөлт хийхгүй бол цаг хугацаа алдах 10, 15 жилээр удаашрах сунжрах ийм одоо бас нөхцөл байдал үүсчихсэн байгаа. Энэ удаагийн хуулиар бол стратегийн ач холбогдолтой нефть боловсруулах үйлдвэр бас цахилгаан станц Улаанбаатар хотын өмнө яг тулгамдаад байгаа гэр хорооллыг орон сууцжуулах, агаар орчны хөрс бохирдлоос салах, түгжрэлийг бууруулах энэ ажлын хүрээнд хийгдэж байгаа Сэлбэ дэд төв бас орж ирсэн. Харамсалтай нь ажлын хэсэг дээр Байнгын хороон дээр санал гарсан байна. Энийг бас зарчмын зөрүүтэй санал хураагдах байгаа гэж ойлгож байна аа.

Энэ 3 төсөл явж одоо жишгээр цаг хугацаандаа дуусаж үр өгөөжөө өгөх юм бол бас одоо энэ дараа дараачийн төслүүдийн маань үүд хаалга 1 дүгээрт нээгдэнэ. 2 дугаарт энэ Монгол Улсын яг энэ дэлхийн энэ хямралтай холбоотой дотооддоо өөрсдөө энэ нефтиэ боловсруулах үйлдвэрээ бариад авах юм бол 50 хүртэлх хувиар дотооддоо асуудлаа шийдэх, Эрдэнэбүрэнгийн УЦС-аа бариад авах юм бол баруун аймгуудыг өөрсдийн дотоодын тогны эх үүсвэрээр хангах ийм бүрэн боломж бүрдэж байгаа юмаа.

Тэгэхээр энэ төслүүд бол яг цаг үеэ олсон энэ хүндрэлтэй үед бушуухан батлагдаад энэ эргэлтэд орох нь зөв өө гэсэн үүднээс энэ хуулийг санаачлан өргөн барьсан. Ажлын хэсгүүд дээр бол олон саналууд гарч зарим саналууд нь бас хэлэлцүүлгийн шатад бас зарчмын зөрүүтэй саналууд гарсан байна. Тэгээд энэ хуулийг маань бас дэмжиж байгаад бас баярлалаа гишүүнд ээ.

С.Бямбацогт: Сархадын Зулпхар гишүүн тодруулж асууя.

С.Зулпхар: Би тодруулгынхаа явцад зүгээр саналаа л хэлье.

Сүүлийн 100 орчим жилийн дэлхийн энэ дайн мөргөлдөөний гол шалтгаан бол энэ эрчим хүчний төлөөх л өрсөлдөөн байгаа. Эрчим хүчний хараат бус байдал бусдыг өөрийнхөө эрчим хүчээр хараатай байлгах гэсэн ийм л өрсөлдөөн байгаа. Тэгэхээр Монгол Улсын хувьд гаднын зээлээр хэрэгжүүлж байгаа төслүүд маань яг бидний эрчим хүчний стратеги, эрчим хүчний хараат бус байдлыг хангахад чиглэсэн ийм төслүүд байгаа юмаа. Тэгэхээр энийг бид энэ хуулийг батлах замаар шуурхай төслүүдээ явуулах, бид эрчим хүчний хувьд аль болох эрсдэл багатай гаднаас хараат бус. Тэр нь эрчим хүч нь бол цахилгаан байна уу, нефть шатах материал байна уу хамаагүй. Энэ чиглэлээр төслүүдээ шуурхай дэмжээд явах ёстой юм байна гэдгийг бид ер нь улс үндэстнээрээ ойлгох ёстой. Энэний төлөө бид хэрүүл тэмцэл эсвэл маргаан хийж байх ерөөсөө шаардлага байхгүй ээ. Биднээс бусад улс орнууд чинь түрүүлж алхаад түрүүлээд яваад байна. Бид тэднээс хоцорч болохгүй гэдгийг энд онцгой анхааръя гэж байгаа юм. Тэгээд би энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байна аа.

С.Бямбацогт: Үг хэлчихлээ. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуултаа асууя алга байна. Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя.

М.Мандхай: Зарчмын хувьд яах вэ ер нь бол манайх ингээд нөгөө төсвийн хязгаартай байдаг учраас томоохон мега төслүүдийг хэрэгжүүлэх ингээд боломж байхгүй төсвийн хязгаарт захирагддаг учраас ингээд төслүүдээ хэрэгжүүлж чадахгүй, авсан зээлээ үргэлжлүүлэн бодитой зардлуудаа гаргаад төсвөө зарцуулаад явах ийм хугацааны хувьд хязгаартай учраас бид нар ингээд хий хүү төлөөд яваад байдаг ийм эрсдэл байгаа. Тэрийг бол ойлгож байгаа. Гэхдээ нөгөө талдаа бас яг ийм тусдаа хууль буюу тусдаа төсөв параллелийн ийм төсөв гаргаад яваад байх нь эргээд бас цаагуураа бид нарт бас эрсдэлтэй гэдгийг харж байгаа. Тэгээд би энэ Сангийн яамнаас асуумаар байгаад байгаа юм.

Одоо бид нар чинь Ай Эм Эсийн 2025 оны одоо энэ 4 дүгээр артикл гээд байсан тэрэн дээр энэ Монголын бодлогыг тэргүүлэх зорилтод төсвийн юу физикал одоо энэ сахилга, төсвийн дүрмийг баримтлах шаардлагыг хангаж байгаа юу гэдгийг би асуумаар байгаа юм. Энэ дээр яг бодитой бас яг энэ дээр макро эрсдэлийг нэмэгдүүлэх үү гэдэг дээр яг тодорхой хариулт өгөөрэй. Мөн төсөвт дарамт үүсэхгүй гэдгийг зардлын тооцооны тайлан дээрээ тусгачихсан байна лээ. Тэрийг бас дахиад би мэргэжлийн энэ Сангийн яамныхнаас асуумаар байгаа юм. Энэ зардлын тооцоонд төсөв дарамт үүсэхгүй гэсэн мөртөө иргэн ААН-д нэмэлт зардал үүсгэхгүй гээд оруулчихсан байгаад байгаа юм. Тэгэхдээ энэ бодлогын төсвийн тэнцэл, энэ өрийн үйлчилгээ, валютын урсгал, тэгээд нөгөө тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүнээ импортоор авах гээд ингээд маш олон импортын дарамт валютын савлагаа гээд эдгээр асуудлууд чинь өөрөө нөгөө макро сувгуудаараа төсөв эдийн засагт нөлөөлөх бодитой тийм боломж байгаа юу гэдэг ийм 2 асуултыг асууя.

С.Бямбацогт: Ажлын хэсэг. Индрийн 3 дугаар микрофон Сангийн яамны газрын дарга Солонгын Тулга хариулъя.

С.Тулга: Гишүүний асуултад хариулъя аа. Ай Эм Эсийн артикл 4 манай 2025 оныг үнэлээд явсан байгаа. Тэрэн дээр өмнөх үнэлгээнүүдээс эерэг үнэлгээ гарсан. Манай төсөв санхүү өрийн удирдлага бол сайн байна аа гэсэн тийм үнэлгээг өгөөд явсан байгаа. Манай төсвийн дүрэмдээ ерөнхийдөө 4 дүрэм байдаг. Орлогын дүрэм. Бид нар бол орлогыг тэнцвэржүүлсэн горимоор тооцдог. Зарлагын дүрэм тэгээд өрийн дүрэм тэгээд тэнцлийн дүрэм гэж байгаа. Өрийн хэмжээнд бид нар Тогтвортой байдлын тухай хуулиар GDP 60 хувь хүртэлх хувь бол манай өрийн тааз байгаа. 2025 оны гүйцэтгэлээр 39.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Төсвийн хүрээний мэдэгдэл дээр 50 орчим хувь байгаа. Энэ зээлүүд ингэж гарснаар хүрээн дээр байгаа 2026 оны 50 хувиас ингээд хэтрэхгүй энэ дотроо ингээд явчих учраас төсөв дээр байгаа яг өрийн дүрэм тал дээр зөрчил байхгүй. Бид хэд гадаад зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл дээр хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр гэж төлдөг байгаа. Ашиглагдаагүй үлдэгдэл дээрээ. Тэрэн дээр бол жилд нэг 50 орчим тэрбум төлж байгаа. Үүний хагас нь эндхийн зээлийн хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны төлбөр байдаг байгаа. Тэгэхлээр одоо энэ зээлийн ашиглалт маань нэмэгдсэнээр бас тэр зардал маань тодорхой хэмжээнд буурах ийм боломжтой байгаа.

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

М.Мандхай: Макро түвшинд яг энэ төсөвтэй харьцуулахад яг хязгаартай байгаа гэж хэлж байгаа юм байна. Тэгэхээр төсөл санаачлагчаас хуулийн төсөл санаачлагчаас асуулт асууя гэж бодож байна. Яг энэ 2028 онд энэ бид нарт одоо ашиглагдаагүй байгаа 12.6 их наяд төгрөг 2028 он хүртэл гэж байгаа юм. Газрын

тосны төсөл бол 2017 оноос хойш яах вэ нөхцөл байдал хойшлогдсон, эрсдэл үүссэн шалтгаан нь ковид энэ тэр гээд зүйлүүд ярьдаг л даа. Тэгэхдээ одоо байгаа энэ хэрэгжүүлэх баг маань яг үндсэндээ төслийн яг менежментийг бүрэн дүүрэн удирдаад авч явах ийм чадвартай баг байгаа юу? 2028 он хүртэл энэ ашиглагдаагүй төсвийг яг зохистой зарцуулаад, энэ дээр нь хяналт тавиад ингээд явах бүрэн боломж байгаа юу? Тэгээд мөн төсөл санаачлагч энэ талын эрсдэлийг нэлээн сайн судалсан байх гэж бодож байна. Энд үүсэх эрсдэл гарвал яах вэ гэдэг асуултыг асууя.

С.Бямбацогт: Хэн хариулах вэ? Наранцэцэгийн Алтаншагай гишүүн хариулъя.

Н.Алтаншагай: Баярлалаа Мандхай гишүүнд. Энэ төслийн баг маань энэ төслөө үргэлжлүүлээд энэ боломж олговол бүрэн дүүрэн хариуцлагатай гүйцэлдүүлж хийж чадах уу гэж байна. Энэ баг маань бас хамгийн сайн шилдэг багууд бүрдсэн л гэж 1 дүгээрт ойлгож байгаа, ойлгогдож байгаа. Гагцхүү энэ мэргэжлийн хүмүүс баг нь бүрдсэн. Гагцхүү одоо яг энэ зээл ашиглалттай холбоотой, санхүүжилттэй холбоотой тэр ажлууд маш их гацалт үүссэн гэсэн ийм тайлбарыг өгч байгаа. Улсын Их Хурлаас бас ажлын хэсгийн гарч, Мөнхбаясгалан гишүүн энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн бас үйл ажиллагаатай танилцах, хяналт шалгалтынхаа ажлын хэсгийг ахалж ажилласан. Тиймдээ ч гэсэн энэ хууль дээр бас орж дэмжиж бас явж байгаа. Тэгээд бас энэ холбогдох газрын тосныхон болон энэ холбогдох хүмүүст бас нэмэлт тайлбар өгөх үү.

С.Бямбацогт: Ажлын хэсгээс нэмэлт хариулт ажлын хэсгийн гишүүн Дэлгэржаргал хариулъя.

Ж.Дэлгэржаргал: Мандхай гишүүний асуултад хариулъя. Сангийн яам Дэлгэржаргал. Төслийн яг хэрэгжилтийг Монгол талаас Монголын газрын тос ТӨК хариуцаж байгаа. Төслийн талбай дээр өнгөрсөн жил 2800 хүн энд одоогийн байдлаар 4500 гаруй хүн, гүйцэтгэгч нь менежментийн компани болон гүйцэтгэгч компани Энэтхэг компани байгаа. Тэгэхээр яг газрын тос боловсруулах үйлдвэрийн зээлийн хэлэлцээрийн дүн бол 6.2 их наядаас 2028 онд зээлийн хэлэлцээрийн хугацаа дуусна. Яг энэ хугацаанд бид нар ашиглах ёстой үлдэгдэл 4.7 их наяд байгаа. Энэ жилийн хувьд яг төсвийн төсөл боловсруулах хугацаанд бол Монголын газрын тос боловсруулах үйлдвэрээс энэ жил ашиглах ёстой шаардлагатай юм бол 1.8 их наядын санал ирүүлсэн байгаа. Тэгэхээр одоогийн төсвийн боломжоор бол бид нар энэ 200 тэрбумыг л олгох боломж байгаа. Хууль батлагдвал 1.8-ыг бүрэн ашиглаад өнгөрсөн үлдэж байгаа 2 жилийн хугацаанд үлдэгдлээ ашиглаад ингээд төслөө 2028 онд бүрэн дуусгах зохион байгуулалттай тийм зорилготой ажиллаж байгаа.

С.Бямбацогт: Батбаярын Жаргалан гишүүн асуултаа асууя алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуулт асууя алга байна. Банзрагчийн Түвшин гишүүн асуултаа асууя алга байна. Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэбат: Энэ гадаад зээллэгийн асуудлыг энийг ашиглаагүйгээс болоод хэчнээн төгрөгийн хүүгийн алдагдал юу төлж байгаа вэ гэдгийг 1 дүгээрт асуумаар байна. 2 дугаарт өчигдөр Орон сууцжуулалтын дэд Сэлбэ дэд төвийг хасчих шиг болсон. Тэгэхээр цаашдаа энэ томоохон гэр хорооллын дахин төлөвлөлт дээр нэмэлт ийм санхүүжилтийн асуудлыг оруулж ирж шийдэхгүй бол энд гэр хорооллын

дахин төлөвлөлт орлогод нийцсэн орон сууц, зорилтот төсөл гэдэг ийм зүйлүүд ер нь байхгүй болчих магадлалтай бас байгаад байна гэж харж байгаа юм.

2 дугаарт энэ дахин төлөвлөлт дээрээ зорилтот бүлгийнхээ төслүүдийг хийхгүй бол яг одоо хуучин шигээ нөгөө том компаниуд нь ингээд сорчлоод аваад тэгээд нөгөө зарж байгаа үнэ нь манай Туулын голын ардуур баригдаж байгаа юм шиг тийм байшингууд байгаа. Тэрийг нь худалдаж авч чадах хүмүүс байхгүй. Тэгээд энэ чинь нөгөө яг зорилтот төсөл гэхээсээ илүү бизнесийн төсөл болчихоод тэрийг нь гадаад зээл гэхээр шийдээд байгаа юм шиг энэ утга учир нь жоохон тийм алдагдах гээд байгаа. Ялангуяа энэ орон сууцын дахин төлөвлөлт дээр. Тэгэхээр энэ орон сууцынхаа дахин төлөвлөлт дээр энэ гадаад зээлийнхээ ашиглалтын асуудлыг хасчихаар ямар сөрөг зүйлүүд гарч ирэх вэ? Бонд босгоод бас тодорхой бондын юмнуудыг авчихсан байгаа. Тэгэхээр энэ хүүгийн алдагдал тэр юуг нь ямархуу хэмжээний алдагдалд орох вэ гэдгийг тодруулж асуумаар байна.

С.Бямбацогт: Одоо гишүүд асуулт асууж энийг дуусаж байна. Чуулганы танхимд гишүүдийг урьж байна. Санал хураалтууд явагдана. Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа.

Энэ гадаад зээлийн ашиглалттай холбоотой энэ бол Монгол Улсад бас маш хэрэгтэй мега төслүүдийг хэрэгжүүлэхэд энэ ажлыг бас явуулахад нэлээн хэрэгтэй байгаа. Монголчууд газрын тос боловсруулах үйлдвэртэй болмоор байна. Газрын тос боловсруулах үйлдвэргүйгээс бид импортын шатахууны хараат байдлаас болж маш хүнд байдалд байгааг Монголын ард түмэн бүгд мэддэг. Баруун бүс нутаг одоо ОХУ-аас маш өндөр үнэтэй эрчим хүч хэрэглэдэг. Үүнийг бас хямдруулах, дотоодоосоо эрчим хүчээ хангадаг болох, эрчим хүчний тусгаар тогтнолоо бий болгох. Эрдэнэбүрэнгийн УЦС-ыг барьж байгуулахад бас энэ хуулийн ач холбогдол бас байгаа. Улаанбаатар хотын бас түгжрэлтэй холбоотой асуудлыг шийдэхэд бас энэ тодорхой асуудлууд орсон байгаа.

Тийм болохоор Их Хурлын гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна. Энэ 15 санал хураалтыг хураагаад энэ хуулиа бас хэлэлцэх эсэх юу саналуудаа цааш нь явуулъя гэж хүсье ээ. Хариулт Сүхбаатарын Эрдэнэбат гишүүний асуултад Жуковын Алдаржавхлан гишүүн хариулна.

Ж.Алдаржавхлан: Манай Сангийн яамныхны өгч байгаа тооцооллоор бол бид нар гадаад зээлийн ашиглалтын энэ хуулиа батлахгүй болохлоор гадаад зээлийн ашиглалтын төлбөрт жил болгон 50 гаруй тэрбум төгрөгийг хий хоосон хүнд зарж байгаа гэсэн тийм тооцоолол байгаа. 2 дугаарт Сэлбэ төслийг яагаад хассан бэ гэхлээр манай ажлын хэсэг дээр Улсын Их Хурлын гишүүн Батболд тэргүүтэй гишүүд санал гаргасан. Тэгээд ажлын хэсгийн гишүүдийн олонхын саналаар Сэлбэ төслийг энэ удаа хассан. Ер нь Сэлбэ төслийг анхнаас нь хамт өргөн барихдаа Сэлбэ төсөл дээр авчихсан байгаа бондыг, босгосон байгаа бондыг зарцуулах үүднээс бас энийг оруулсан. Тэгэхдээ Улсын Их Хурлын гишүүд бас санал хураалтын явцад шийдвэр гаргах юм бол Сэлбэ дэд төвийн асуудал бас эргэж орох бололцоотой.

С.Бямбацогт: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн тодруулж асууя.

С.Эрдэнэбат: Үгүй тэгээд бид нар төсөл нь явчихсан. Одоо миний харж байгаагаар тэр хойд талын хэсэг чинь бүгдээрээ дахин төлөвлөлт болгоод айл орон

нутгийн газрыг нь чөлөөлөөд яг ид өрнөж байхад нь дундаас нь ингээд зогсоочихоор энэ төсөл чинь гацаад бүүр орон сууц ч байхгүй, станц ч байхгүй нөгөө нэг олон газраа чөлөөлүүлсэн болон хүлээгдэж байгаа тэр төслүүд чинь бүгдээрээ зогсоно гэсэн үг үү? яах юм тэрийг одоо цааш нь яаж явуулах юм эс үгүй бол үнэтэй мөнгө олж ирж энэ төслийн метр квадратын үнэ чинь шингээд л нөгөө ард түмний л карманаас юм л гарах юм болох байх л даа. Миний түрүүний хэлээд байдаг нөгөө том том хувийн компаниуд нь аваад л тэгээд тэрийгээ 7, 8, 9, 10 сая гээд л ингээд зарах л байлгүй.

Уул нь төслөөрөө 4 сая гэсэн байх аа тиймээ метр квадрат нь Сэлбэ дэд төслийн орон сууцнууд, багш нар, эмч нар, хөгжлийн бэрхшээлтэй иргэд орох гээд хүлээгээд байгаа ийм төсөл байгаа гэж би ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд энэ Төсвийн байнгын хорооныхон яагаад тэрийг ямар үндэслэлээр хасчихсан юм. Энэ нь төсөл нь яваад.

С.Бямбацогт: Ажлын хэсэг Төсвийн байнгын хорооны дарга Нанзадын Наранбаатар хариулъя аа. Төсвийн байнгын хороон дээр ямар үндэслэлээр Сэлбэ хотхоны төслийг хасчхав гэж асууж байна.

Н.Наранбаатар: Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Анх бол ингээд 3 төсөл орж ирсэн. Эрдэнэбүрэн нефтийн үйлдвэр тэгээд Сэлбэ дэд төвийн төсөл гээд. Тэгээд Төсвийн байнгын хороон дээр гишүүд санал гаргаад Сэлбэ дэд төвийг хасъя гэдэг зарчмын зөрүүтэй санал гаргаад ингээд энэ нь дэмжигдээд явсан ийм л асуудал байгаа. Одоо энэ чуулганы хуралдаан дээр санал хураагаад бас гишүүд дэмжих, дэмжихгүй бас эргээд бас босох ийм боломжтой л гэж Эрдэнэбат гишүүнд хариулъя.

С.Бямбацогт: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо. Зарчмын зөрүүтэй 15 санал байна. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

111 гишүүн өглөө ирцдээ орсон. Үдээс өмнөх хуралдааны чуулганы ирцэд. Одоо санал хураалтад бэлэн болсон 25 гишүүн байна аа 25 гишүүн. Энэ танхимд нэлээн олон гишүүн байх юм. Санал хураалтдаа бэлтгэе гишүүд. Танхимд одоогоор яг 48 гишүүн байна гэж байна. 48 гишүүнээс 25 гишүүн санал хураалтад бэлэн болсон. Ирцдээ 111 гишүүн орсон, 48-уулаа ч гэсэн санал хураалтдаа бэлдээд энэ санал хураалтууд бас дэмжигдэхэд хэцүү байна. Түрүүн ярьсан газрын тос боловсруулах үйлдвэр монголчууд өөрсдөө дотооддоо бас шатахуунаа үйлдвэрлэдэг болох монголчуудын хүсэл байгаа монголын ард түмний. Эрчим хүчний тусгаар тогтнолоо бий болгох энэ томоохон сэргээгдэх эрчим хүчний цахилгаан станцаа барих чухал байна. Бүгдээрээ л дэмжиж байгаа байх. За дахиад санал хураалтдаа бэлдье. 44 гишүүн боллоо. Санал хураалтад бэлдсэн. Бэлэн болсон 46 гишүүн байна, бэлэн бус 65 гишүүн болчихоод байдаг. Тэгээд ямар ч санал хураалттай байгаад бүгд дэмжээд дэмжээд энэ асуудал уначих гээд байна шүү дээ.

Ирцийн санал хураалт, бүртгэлийн санал хураалт. Бүртгэлийн санал хураалтад ингээд 111 гишүүнээс 46 гишүүн л танхимд сууж байна. Тэгээд ирцдээ орчихоод ингээд 65 гишүүн гараад явчихдаг. Тэгээд энэнээс чинь болоод л нөгөө

төрийн ажил гацдаг. Энэнээс чинь болоод л Улсын Их Хурлын нэр хүнд унаад байгаа шүү дээ. Өнөөдөр яах вэ бас нэг хүндэтгэн үзэх шалтгаан бол АН-ын бас Үндэсний бодлогын хороо хуралдаж байна. Харьцангуй ирц багатай байх шиг байна. Бусад гишүүд ирцдээ орчхоод ингээд чуулгандаа суухгүй алга болчихдог. Тэгээд тодорхой цагт зарлаад хонх дуугараад хуралддаг, ирцдээ орж саналаа, санал хураалтдаа биеэрээ л оролцдог болчихмоор байгаа юм. Санал хураалтад ирцдээ орчхоод санал хураалтад оролцдоггүй бол тодорхой хариуцлага тооцдог болчихвол бас ингээд өглөө ирцдээ орчхоод би ажилдаа ирсэн гээд бүртгүүлчхээд алга болчихдог энэ асуудал бас цэгцрэх байх аа.

Тэгээд чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд бас иймэрхүү өөрчлөлт бас оруулахаар төлөвлөж байгаа шүү гэдгийг бас гишүүдэд хэлье. Нэгэнтээ ирц хүрэхгүй юм чинь энэ асуудлыг Пүрэв гарагийн 10 цагаас санал хураалт явуулъя тийм.

Дараагийн асуудалдаа оръё оо.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна аа.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Төсвийн байнгын хорооны дарга Нанзаддын Наранбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна. Энэ бас Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барьсан шатахууны гаалийн татварыг чөлөөлөх, шатахууны үнийг өсгөхгүй байхтай холбоотой асуудал шүү. Гишүүд бас уул нь суугаад явуулчихвал энэ саналаа хураагаад дуусчихвал их зүгээр байгаа шүү. Ирцдээ орохгүй байгаа гишүүдийг ирцдээ орохыг урьж байна аа. Юу санал хураалтад ирэхгүй байгаа танхимдаа ирэхгүй байгаа гишүүдийг. За Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд Тогтоолд нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар дээрх тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа. Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно оо.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тогтоолын төсөлд нэмж тусган, төслийн агуулга зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг бүтцийн шинжтэй засварыг хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон Байнгын хорооны танилцуулгыг Та бүхэнд хүргүүлсэн болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Тогтоолд нэмэлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Улсын Их Хурлын Гонгорын Дамдинням Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Чулууны Хишигдалай Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын газрын дарга, Сангидоржийн Баярмаа ГЕГ-ын Татварын орлогын газрын дарга, Чойдоржийн Чимгэрэл ГЕГ-ын барааны ангиллын хэлтсийн дарга.

Улсын Их Хурлын гишүүд байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэгт болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя алга байна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуултаа асууя алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо бас Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад ирцэд 111 гишүүн орсон санал хураалтад одоо бэлэн 31 гишүүн. Энэ танхимд сууж байгаа гишүүд 31-ээс олон байх юм. Тэгээд одоо нэн яаралтай бас шатахууны гаалийн татвар чөлөөлөхтэй холбоотой асуудал байгаа дизелийн түлшний. 1999 оноос хойш чөлөөлөөд ирчихсэн. Засгийн газраас нэн яаралтай горимоор өргөн барьсан. Тэгээд санал хураахаар уначих гээд байдаг.

Үдээс хойш АН-ын бүлгийнхэн 2 цагаас чуулганы хуралдаанд орж ирж амжих болов уу? Санал хураалтыг 2 цагаас 14 цагаас болгоод хойшлуулчих уу? Энэ нэн яаралтай горимоор орж ирсэн учраас 14 цагаас санал хураалт хойшлууллаа.

Дараагийн хэлэлцэх асуудал.

11.17 цаг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нарын гишүүд 2026 оны 3 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна аа.

Хууль санаачилсан илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Пүрэвжавын Сайнзориг танилцуулна. Индэрт урьж байна аа.

П.Сайнзориг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Дэлхий дахинаа цахим спортын төрөл маш хурдацтай хөгжиж байгаа бөгөөд энэ төрлийн спорт нь 1970-1980 онд видео тоглоом гарч ирсэн үеэс эхлэн өнөөдрийг хүртэл хөгжихдөө дэлхий даяар мэргэжлийн лигүүд байгуулагдаж, үзэгч дэмжигчдийн тоо тэрбумаар тоологдож, шагналын сан ч асар их өндөр дүнд хүрч

байна аа. Түүнчлэн энэ спортыг дагаад спонсоршипийн асуудал явж байдаг учраас амжилттай байх тусам томоохон компаниуд хөрөнгө оруулж ивээн тэтгэх, хамтран ажиллах олон боломжуудыг эрэлхийлж байдаг аа. Нөгөө талаас спонсоршип цалин, стрийм хандив, нэмэлт орлого зэрэг шагналын мэргэжлийн тамирчдын хувьд орлогын эх үүсвэр байдаг боловч манай улсад энэ боломжууд одоогоор бүрэн утгаараа бүрдээгүй байгаа учраас тамирчдад гадаадын тамирчдын адил дээрх боломжуудыг эдлэх нөхцөл боломж хараахан бүрдээгүй байна.

Биеийн тамир спортын тухай хуульд зааснаар Монгол Улс УИХ нь Биеийн тамир спортын талаарх төрөөс баримтлах бодлогыг тодорхойлох, Татварын ерөнхий хуулиар татварыг зөвхөн Улсын Их Хурал тогтоож бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох зохицуулалттай. Өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа ААНОАТ-ын тухай хуулийн 22.9 дэх хэсэгт албан татвар төлөгчдийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй зарим үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэлд тооцох үндсэн хөрөнгөд оруулан хөрөнгө оруулалт харилцан хамааралгүй бусад этгээдэд олгосон санхүүгийн дэмжлэг хандивыг зардлыг тус хуулийн 20.1-д заасны дагуу ноогдуулсан албан татвараас хасаж хөнгөлөх буюу хөнгөлөх үнийн дүн нь тухайн татварын жилийн татвар ноогдох орлогын нэг хувь хүртэл байхаар хуульчилсан. Үүнд Спортын барилга байгууламж барьж байгуулах, ашиглах, олимпын төрлийн тэмцээн зохион байгуулах, МҮОХ Монголын үндэсний пара олимпын хорооны бүртгэлтэй олимпын төрлийн спортын холбоо, түүнд бүртгэлтэй баг, тамирчин нь дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэг дээрх татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамаарч байна аа.

Аливаа салбарыг ялангуяа спортыг аль нэг төрлийг хөгжүүлэхэд зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт төрийн дэмжлэгт тулгуурлах бус хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэмжих хамтран ажиллах боломжийг нээж өгөх нь оновчтой бөгөөд ингэснээрээ Монгол Улсыг дэлхий дахинаа сурталчлан таниулахаас гадна үндэсний ААН-ийн энэ төрлийн спортод хөрөнгө оруулах аливаа төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх хамтран ажиллах боломж бүрдүүлэх, мэргэжлийн тамирчдыг бэлтгэх, тухайн спортын төрөл дээр суурилсан эдийн засаг маркетингийн үйл ажиллагаа хөгжүүлэх боломжтой байдаг аа.

Иймд хуулийн төслийн тандан судалгааны тайлан болон хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн ААНОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 9.6 дахь заалтад Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн Үндэсний шигшээ баг, түүний харьяалагддаг Спорт холбоо гэх агуулгыг нэмэх зохицуулалтыг боловсруулан хэлэлцүүлж байна аа. Ингэснээр ААНБ нь и-спорт шатрын спортын Үндэсний шигшээ баг тамирчин тэдгээрийн харьяалагдах спорт холбоотой дээрх хуулийн дагуу эдэлж буй татварын хөнгөлөлтийн хүрээнд хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлэх хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Эрдэнийн хамтаар боловсруулан хэлэлцүүлж байна аа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн Үндэсний шигшээ багийн хэрэгцээнд зориулсан гадаад улсын иргэн хуулийн этгээдээс өгсөн хандив буцалтгүй тусламжаар олгосон тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлөх, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх агуулга бүхий хуулийн төслүүдийг мөн боловсрууллаа.

Хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг дэмжиж өгөхийг та бүгдээсээ хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүнд баярлалаа.

Төслүүдийн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баатаржавын Мөнхсоёл танилцуулна аа. Индэрт урьж байна.

Улсын Их Хурлын гишүүн Тилеуханы Аубакирын урилгаар Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн англи хэлний улсын олимпиадад оролцох багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ сурлагад нь өндөр амжилт хүсье. Олимпиадаа бас оролцож амжилт гаргаарай. Нийт Их Хурлынхаа гишүүдийн өмнөөс хүсэн ерөөе. Индрийн микрофон.

Б.Мөнхсоёл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас 2026 оны 3 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төсвийн байнгын хороо 2026 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалд спортын аль нэг төрлийг хөгжүүлэхэд зөвхөн төсвийн хөрөнгө оруулалт төрийн дэмжлэгт тулгуурлах бус хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар дэмжих, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх үүднээс ААНОАТ-ын тухай хуульд шинээр нэмэгдэх спортын төрөл тэр дундаа и-спортын Үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин дасгалжуулагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалтыг тусгасан байна аа.

Уг асуудлыг хуульчилснаар шинээр нэмэгдэх спортын төрлийг дэмжих, багийн спортыг хөгжүүлэх, спортын төрлүүдэд хүний нөөц бэлтгэх, амжилт гаргах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой талаар хууль санаачлагч үзэл баримтлалдаа дурджээ. Хуулийн төслийг Ди парламент цэг мн цахим хуудаст байршуулж иргэд олон нийтийн санал авч байгаа болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал ААНОАТ-ын тухай хуулиар татвар төлөгчийг нийгмийн хариуцлагын хүрээнд олимпын төрлийн спортын тэмцээн зохион байгуулах, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгт тухайн татварын жилийн татвар ноогдох орлогын нэг хувь хүртэл хэмжээгээр албан татвараас хөнгөлөх зохицуулалттай. Энэ хүрээнд тодорхой нэг төрлийн спортыг нэрлэн зааж татварын хөнгөлөлт үзүүлэх нь оновчтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн Үндэсний шигшээ баг түүний харьяалагддаг спорт холбоо, мэргэжлийн тамирчин, дасгалжуулагчид олгосон санхүүгийн дэмжлэгийг ААН-ийн болон гааль нэмэгдсэн өртгийн албан татварын хөнгөлөлт үзүүлэх нь зүйтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд и-спортын Үндэсний шигшээ багийн мэргэжлийн тамирчин дасгалжуулагчид санхүүгийн дэмжлэг үзүүлэх нь хялбаршуулсан татварын хөнгөлөлтөд хамрагдах эсэх, Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар спортын Үндэсний шигшээ баг, түүнд бүртгэлтэй тамирчинд олгосон ААНБ иргэн болон бусад этгээдээс өгсөн бүх

төрлийн шагнал урамшуулал, тэдгээртэй адилтгах орлогыг татвараас чөлөөлөх асуудлыг Засгийн газраас өргөн мэдүүлэх татварын багц хуулиудтай нэгтгэх боломжтой эсэх талаар асуулт асууж хариулт авлаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа хууль санаачлах эрхийн хүрээнд хязгаарт татвар, эрүү, иргэн болон зөрчлийн тухай анхдагч хуулийн төслийг зөвхөн Засгийн газраас санаачлах бусад өөрчлөлтийн төслийг хууль санаачлагч санаачилж болох ч гааль татвартай холбоотой зохицуулалтыг бодлогын хүрээнд цогцоор нь боловсруулж хэлэлцүүлэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу бүрдүүлсэн үндэсний шигшээ баг түүний харьяалагддаг спорт холбоог ААНОАТ-аас хөнгөлөхийг дэмжиж байгаа. Харин нэмэгдсэн өртгийн албанд болон гаалийн татвараас хөнгөлж чөлөөлөх зохицуулалтуудыг дэмжихгүй байгаа талаар санал хэлсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Татварын хуулийн төслүүдийг дэмжиж байгаа бөгөөд хууль хэрэгжих хугацааг Төсвийн тухай хуулийн холбогдох заалтад нийцүүлэн дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлэхээр төсөлд тусгах нь зүйтэй. Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг и-спортын төрлийг үндэсний болон олимпын түвшний спортын төрлүүдтэй адилтгаж татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах нь нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэйг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Монголын Улсын шигшээ багийн тамирчдын олон улсын тэмцээнд оролцох техник тоног төхөөрөмж худалдан авах зардлыг татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд хамруулах нь төсөвт үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага бөгөөд Монгол Улсын нэр хүндийг дэлхийн тавцанд гаргах, залуучуудыг спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг ач холбогдолтой тул хуулийн төслийг дэмжиж байгаа талаар санал хэлсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх санал хураалт явуулахад ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн 56.3 хувь дэмжсэн бөгөөд хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно оо.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Бямбацогт: Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг та бүхэнд танилцуулъя. Балдангомбын Бат-Эрдэнэ Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын яамны ТНБД, Чойгүнсэнгийн Чимэдсүрэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Баяраагийн Урьболд Соёл спорт аялал жуулчлалын яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Дондогийн Сайханчулуун Татварын ерөнхий газрын Татварын

удирдлага олон улсын татварын газрын дарга, Бат-Өлзийгийн Буяннэмэх Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Эрдэнэсайханы Билэгт Биеийн тамир спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч.

Улсын Их Хурлын гишүүн Баатархүүгийн урилгаар Цэндийн Баатархүүгийн урилгаар нийслэлийн ерөнхий боловсролын 72 дугаар сургуулийн 12-ын А ангийн сурагчид, багш нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсье ээ. Амьдралд нь аз жаргалыг хүсье. Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс.

Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна аа.

Жадамбаагийн Баясгалан гишүүн асуултаа асууя. Алга байна. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Д.Энхтүвшин: Энэ өргөн мэдүүлсэн хууль 3 татварын хөнгөлөлттэй холбоотой асуудал байгаа. 1 дүгээрт нь ААНОАТ 22.9 буюу өнгөрсөн 2 жилийн өмнө баталсан нэг хувийн хөнгөлөлттэй холбоотой энэ хөнгөлөлтөд спортын үндэсний шигшээ багийг юу багтай ийм багуудад оруулж ирсэн зориулсан дэмжлэгүүдийг энэ татварын хөнгөлөлтөд оруулахаар оруулж ирж байгаа юм байна лээ. Тэгээд энийг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ дээр хамрагдах хүрээ нь бол шатар болон и-спортын холбоо л энд орохоор юм байна лээ. Тэгэхээр энэ асуудлыг бол төсөв дээр ямар нэгэн нөлөө байхгүй учраас ААН-үүдтэй хамтарч ажиллаад энэ зардал мөнгөө шийдүүлэх энэ бололцоо боломж нээгдэж байгаа учраас энэ асуудлыг нь дэмжиж байгаа юм.

Тэгээд нөгөөдөх гааль болон НӨАТ-тай холбоотой асуудлууд нь бол яг гаальтай холбоотой асуудал нь тодорхой хэмжээгээр хуулиар зохицуулах бололцоо боломж байгаа учраас тэр хүрээгээрээ зохицуулах бололцоотой. НӨАТ-ын асуудал нь ч гэсэн хөнгөлөлт чөлөөлөлтийг ер нь ААН-үүд болохоор аль болохоор багасгая, бүгдээрээ татвар төлдөг больё гэж байгаа үед бас, нэгд.

Хоёрдугаарт энэ татварын хууль бас өргөн барих гэж байгаа цаг үе таарч байгаа учраас энийг бол тэр татварын хууль дээрээ оруулаад явсан нь зөв юм болов уу гэсэн ийм саналтай байгаа юм. Тэгээд энийгээ бас байнгын хороон дээр хэлсэн байгаа юм. Тэгээд байнгын хороон дээр бас нэг асуулт асуугаад авч чадаагүй нэг хариулт байгаа. Энэ нэг хувийн 22.9-тэй холбоотой хэрэгжилтийн талаар нэг зарим одоо жишээлбэл яамдууд бол энэнтэй холбоотой журмуудаа гаргачихсан байгаа юм. Тэгээд энд орхигдож байгаа нэг юм болохоор их, дээд сургууль, ШУА-д судалгаа шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэг гэдэг журам одоо болтол гараагүй байна. Өөрөөр хэлбэл ААН-үүд зарим судалгааны байгууллагууд их сургуулиудыг түшиглээд энэ судалгаа шинжилгээний ажлууд хийх ийм хүсэл сонирхлууд байгаад байна. Энийг ААН-үүдтэйгээ яриад шийдүүлэхийг хүсээд байна. Зарим тинк танк ч гэдэг юм уу бодлогын судалгааны асуудлууд хүртэл ер нь улсад хэрэгтэй байгаа энэ судалгаатай холбоотой асуудлууд дээр бас энийг дүрэм журмыг нь гаргаж өгч дэмжих зайлшгүй шаардлага байгаад байна аа. Тэгээд энэ талаар энэ журам нь хэзээ гарах юм? Энэ Шадар сайд хариуцдаг юм шиг байна лээ. Тэгээд энэ журам гарахгүй байна. Энэ хэзээ гарах юм. Энэ талаар мэдээлэл өгөөч.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Пүрэвжавын Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Энхтүвшин гишүүнд бас баярлалаа. Бас Хууль зүйн Төсвийн байнгын хороон дээр бас саналаа тодорхой хэлсэн. Ер нь зүгээр яах вэ биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу Үндэсний шигшээ баг бүрдүүлсэн 26 үндэсний шигшээ баг байгаа юм байна лээ. Үүний 24 нь олимпын төрлийн спорт буюу пара олимп болон ҮОХ-нд одоо гишүүнчлэлтэй ийм спортын чиглэл төрөл холбоодууд байгаа. Яг эндээ үлдчихээд байгаа 2 спорт байгаа нь үндэсний шигшээ байгуулчихсан нь и-спорт болон шатар байгаа. Тэгэхээр энэ томьёолол энэ 2 чиглэлийн спортыг ААНБ-ын энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн хүрээнд ААН байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг л олгож байгаа юм. Илүү нэмэгдүүлж олгож байгаа юм. Тэгэхээр энэ зүйлээрээ бас байгаа гэдэг зүйлийг бас хэлье. Тэгээд дагаж байгаа 2 хууль дээрээ яах вэ зүгээр спортыг дэмжих чиглэлдээ л байгаа.

Ер нь зүгээр спорт гэдэг бол энэ нийгэм дэх иргэдийн ялангуяа хүүхэд залуучуудын бас бие бялдар, өсөлт хөгжил, хүмүүжил төлөвшил дээрээс нь энэ нийгэм дэх стресс гэдэг юм уу энэ зүйлүүдийг арилгахад л байгаад байгаа. Тэгээд энэ Үндэсний шигшээ багт зориулж өгч байгаа энэ тоног төхөөрөмжүүдийг ер нь гааль, НӨАТ-аас чөлөөлчихвөл яадаг юм бэ. Энэ чинь ирээдүйтэй буюу хүүхэд залуучуудад оруулж байгаа л хөрөнгө оруулалт байгаад байгаа юм. Энэ дээр нэг их олон тэрбумын ашиг хийгээд ч гэдэг юм уу ийм зүйлүүд байдаггүй. Зүгээр бодит жишээнүүд байдаг юм байна лээ. Тодорхой ингээд спортын тоног төхөөрөмжүүдийг авах гээд ирэхээр хандив тусламжаар ирсэн юмыг авах гээд тэгэхээр гааль, НӨАТ-аа төлж чадахгүй эцэг эхчүүдээс нь цуглуулаад л ингээд нэг хүүхэд залуучуудын явдаг ийм спортын холбоодууд нэлээдгүй байгаа. Спорт холбоодууд бас эдийн засгийн хувьд хараахан бэхжиж чадаагүй байгаа.

Ер нь зүгээр цаашдаа Монгол Улсад бас энэ спортын эдийн засгийг зөв хөгжүүлэх замаар энэ хүүхэд залуучуудынхаа бас цагаа боловсон өнгөрүүлэх, бие бялдар энүүгээр Монгол Улсыг сурталчлан таниулах, энүүгээр одоо бас анхаарах сурталчлан таниулах энэ үйл ажиллагаанд бас спортыг дэмжих замаар бас хийх ийм зайлшгүй шаардлага бол байгаа. Тэгээд энэ хүрээндээ бас энэ хуулийн төслүүдийг боловсруулсан гэдэг зүйлийг хэлье.

Сангийн яамнаас нь тэр дүрэм журмууд яагаад гарахгүй байгаа талаар хэлж болох уу? Яг энэ спорт биш бусад салбарын асуудлууд байх шиг байна тиймээ. Тэгэхээр энэ дээр тэр 22.9-д заасны дагуу гарах ёстой журам дүрмүүд аль аль яамдууд нь гараагүй талаарх мэдээллийг бас Сангийн яамнаас өгөхийг хүсье ээ.

С.Бямбацогт: Сангийн яам бас нэмээд тэр Энхтүвшин гишүүний тэр нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, гаалийн албан татвараас чөлөөлөхдөө хэр бас үр дагавартай вэ? Тэрийг нь бас тодруулаад хэлчхээрэй. 4 дүгээр микрофон индрийн.

Ч.Чимидсүрэн: Нэмэлт мэдээллийг өгье. Сангийн яам Татварын бодлогын газар Чимэдсүрэн. Түрүүний хэлсэн шинжлэх ухаантай холбоотой зохицуулалтууд бий. Энэ 22.9 дээр бас хөнгөлөлт эдэлж болохоор байгаа. Энэ дээр Эдийн засгийн хөгжлийн яаман дээр бол тэр шаардлага стандартаа боловсруулаад санал авах түвшиндээ бол байгаад явж хэрэгжиж байгаа. Бусад салбаруудынх буюу одоо

стандарт шаардлага хангасан 10 стандарт нь бол хангагдчихсан. Ингээд хэрэгжилт нь бол явж байгаа гэдгийг хэлье. Нэмэгдсэн өртгийн албан татвар, гааль эд нартай холбоотой бол яах вэ нөлөөлөл тооцоо бол бага байгаа. Яах вэ нэмэгдсэн өртгийн албан татварыг бид нар бол өмнөх Засгийн газрын өмнөх Засгийн газраас буюу 2025 оны 12 сарын 30-нд бол Улсын Их Хуралд нэмэлт, өөрчлөлт оруулахаар бол өргөн барьсан боловч одоогоор татчихсан. Одоо дахиад бас татварынхаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар явагдаж байгаа. Тэгээд тэр түвшиндээ бол энэ судалгааны ажлуудыг хийх бололцоотой гэж бодож байна аа.

С.Бямбацогт: Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

Д.Энхтүвшин: Энэ татварын хуулийн 22.9-өөр бас энэ нийгмийн асуудлуудыг заавал төсөв харж биш хувийн хэвшил ААН-үүдтэй хамтарч шийдэх энэ бололцоо боломжийг том боломжийг нээсэн байгаа. Тэгэхээр энэний хэрэгжилт бас маш чухал байгаа. Ялангуяа төсөв зардал мөнгө хэцүү байгаа үед бол. Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийг бас та бүхэн нэлээн анхаарч энэ хэрэгжилт дээр нь анхаараасай гэж хэлмээр байна. Тэгэхгүй бол ААН-үүд бас тасралтгүй гомдол ирж байгаа. Яг энэ хуульд байгаа мөртлөө энийг чинь бариад очихоор татварынхан бол энийг чинь ерөөсөө зөвшөөрөхгүй байна аа. Ийм ийм юм болохгүй, энэ нь болохгүй гэдэг асуудлууд үүсээд байгаа юм. Тэгээд дээр нь саяын энэ Эдийн засгийн хөгжлийн яаманд бас юу Энхбаяр сайдад бас юу сануулж хэлье. 22.9.8 дээр их дээд сургууль ШУА-д судалгаа шинжилгээний зориулалтаар олгосон тэтгэлэгтэй холбоотойгоор яаж хөнгөлөлт үзүүлэх журмаа та ойрын хугацаанд гаргаач ээ. Энэ хууль хэрэг чинь ингээд батлагдаад 2 жил болчихлоо. Тэгээд одоо болтол ганцаараа гаргаагүй байна аа. Тэгээд энийгээ гаргаач ээ гэж хэлмээр байна. Баярлалаа.

С.Бямбацогт: Яагаад удаад, яагаад гаргахгүй байгаа талаараа ажлын хэсгээс хариулъя. Хэн хариулах вэ? Саяын журам. Эдийн засгийн хөгжлийн яамныхан тэр журам дээрээ анхаараарай. Удаахгүй ажлаа хурдан шуурхай хийх ёстой шүү. Болдын Уянга гишүүн асуултаа асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе. Энэ хуулийн төслийн ерөнхий агуулгыг нь дэмжиж байгаа. Гэхдээ хэд хэдэн тодруулах асуулт байна. Тэгээд танай ажлын хэсэгт бас яг олон улсын татварын тэр судалж байдаг газрын дарга нь бас орсон байгаа юм байна. Тэгэхээр яг тэнд ажлын хэсгийн гишүүнээс тодруулаад асуултуудыг асууя аа.

Тэгэхээр олон улсад и-спортын орлогын татварын зохицуулалт их шинэ ойлголт гэж судалж харлаа. Ихэнх улсууд ердийн горимоор бол татвар ноогдуулдаг юм байна. АНУ, Хятад, Европын холбооны хэд хэдэн улсууд нь болохоороо дандаа ердийн горимоор буюу татвар ноогдуулдаг, хөнгөлөлт эдлүүлдэггүй, тэгсэн мөртөө төрийн бодлогоор бол хөгжлийг нь дэмжиж явдаг юм байна. Манайд ч гэсэндээ энэ боломж одоогоороо байгаа гэж харж байгаа. Тэгэхдээ яах вэ зүгээр яг энэ хуулийн төсөлтэй холбоотой агуулга болохоор Өмнөд Солонгос тэгээд Японд татварын хөнгөлөлт олгох боломжтой гэдэг байдлаар болно, болохгүй гэсэн байдлаар бас орсон байна аа. Тэгэхээр энийг л бид нар нутагшуулах гэж энэ хуулийн зохицуулалт орж ирж байгаа байх гэж харж байгаа юм.

Тэгэхдээ Засгийн газраас 2025 оны 12 дугаар сард дэмжихгүй санал ирсэн юм билээ. Тэгэхээр тэрэнтэй холбоотой бас асуултууд байгаа. Тэгэхдээ тэгэхээр энэ ажлын хэсэгт орсон яг энэ олон улсын татварын асуудлыг сайн мэдэж байгаа

газрын дарга нь түрүүний миний хэлсэн асуудлуудыг тайлбарлаад яагаад шинэ ойлголт юм бэ, яагаад ердийн горимоор явсан хэвээр байгаа юм бэ? Тэрэн дээр нэг нэмэлт тайлбар хэлээд өгөөрэй.

За энэ Засгийн газраас болохоороо ирсэн санал энэ хуулийн төслийг дэмжихгүй гэж хэлсэн байгаа шалтгааныг нь жаахан ойлгох гэж оролдлоо л доо. Тэгээд энэ магадгүй спортыг дэмжих сан гэж байдаг. Энэнтэй холбоотойгоор энэ и-спорт энэ үндэсний шигшээ баг нь байгуулагдчихаад тэгээд олимпын бус спорт байгаад байгаа учраас бас энэ татварын хөнгөлөлтөд орохгүй байгаа байх гэж харвал спортыг дэмжих сангаараа дамжуулаад бид нар баг тамирчдадаа дэмжлэг үзүүлчхэж болох юм шүү. Тэгэхээр энэ зохицуулалт яагаад сайн хэрэгжихгүй байгаа юм бол оо? Энийг хууль санаачлагчаас асууя.

Тэгээд яах вэ энэ хуулийг дагалдуулаад бас энэ и-спорт шигшээ баг түүнд бүртгэлтэй тамирчинд олгосон гадаадын ААН байгууллагаас ямар нэгэн байдлаар шагнал урамшуулал ирэх юм бол албан татвараас чөлөөлье. Ямар нэгэн тоног төхөөрөмж бас орж ирэх юм бол Нэмэгдсэн өртгийн албан татвараас бас чөлөөлөх ийм зохицуулалтуудыг бас тусгасан байгаа юм байна лээ. Тэгээд энэтэй холбоотой магадгүй бас Засгийн газраас эсрэг санал өгсөн юм болов уу? Энэ дээр Засгийн газрын ер нь энэ санал дээр ямар хариултыг өгөх вэ?

Тэгээд татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон энэ асуудал болохоороо Татварын ерөнхий хуулийнхаа 4.2-оороо засгаас эсвэл төсөв хэлэлцэх үеэр дагаж орж ирэх ёстой байсан зохицуулалт биш үү? Энэ дээр бас нэмээд хариулаад өгөөрэй.

С.Бямбацогт: Хууль санаачлагч Пүрэвжавын Сайнзориг гишүүн хариулна.

П.Сайнзориг: Уянгаа гишүүн маань бас материалаа дутуу харсан юм байна аа. Засгийн газар бол энэ ААНОАТ-ын тухай хууль дээр юм яриагүй. Энэ дээр төсөвт үзүүлэх нөлөөлөл байхгүй. Одоо хэрэгжээд явж байгаа нэг хувийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтөд и-спорт шатрыг оруулах уу, үгүй юү гэдэг л заалт байгаа. Харин Хүн амын орлогын албан татварын тухай хуулийн хууль дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг бол анх санаачлаад явж байсан энийг дагалдуулаад. Засгийн газраас өгсөн саналын дагуу өргөн барихдаа энэ хуулийг өргөн бариагүй ээ, татсан гэсэн үг. Өөрөөр хэлэх юм бол ингэж одоо и-спортын гэдэг юм уу энэ чиглэл дээр тамирчдын олж байгаа орлогыг татвараас чөлөөлөх шаардлага байхгүй ээ гэдэг энэ саналыг нь Засгийн газар өгсөн. Энэ дээр дэмжээгүй. Энэ саналыг нь хууль санаачлагчийн хувьд хүлээж аваад хуулийн төслийг өргөн бариагүй байгаа. Тэгэхээр энэ дээр бас таны хэлж байгаа асуудлыг аль хэдийн шийдсэн гэсэн үг.

2 дугаарт яах вэ Спортыг дэмжих сангаар энэ залуучуудад бас цалин урамшуулал олгосон юм билээ. Тэгээд олон нийт шуугиад нэр хүндийн асуудал дээр нь нөлөөлсөн учраас энэ залуучууд цалингаа цаашдаа энэ сангаас янз бүрийн төрөөс дэмжлэг авахгүй л гэж байгаа юм. Энэ хуулийн маань агуулга ерөөсөө төрөөс дэмжлэг үзүүлэх гээд байгаа зүйл биш. ААН байгууллагууд тэр эдэлж байгаа нэг хувийн хөнгөлөлтийнхөө хүрээнд энэ и-спорт шатрын холбоотой хамтарч ажиллах тэр бололцоог бүрдүүлье л гэж байгаа юм. Энэ и-спорт өөрөө хэдэн зуун сая үзэгчтэй болчихсон, маш том хэмжээний маркетинг болон спортын эдийн засаг хөгжүүлэх бололцоотой салбар байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нь юу

гэдэг юм хамтарч ажиллах замаар манай ААН байгууллагууд өөрсдийн бараа үйлчилгээг бас сурталчлах болон эдгээр одоо залуучууд энэ ҮШБ-ийг бүрдүүлж байгаа энэ хүрээнд нь дэмжиж хамтарч ажиллах энэ бололцоог бүрдүүлэхээр байгаа юмаа. Ийм зүйлийг танд хэлье. Тэгээд нэмэлтээр бас Сангийн яамнаас хариултыг хэлнэ үү.

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон. Сангийн яам ажлын хэсэг.

Ч.Чимэдсүрэн: Гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье. Тэгэхээр Сангийн яам нь яах вэ Засгийн газрын зүйл дээр энэ нь и-спортын асуудлыг дэмжихгүй гэсэн утгаар биш зүгээр хуульд нэмэлт ийм шигшээ баг болон түүний харьяалах спорт холбоо гэхгүйгээр 22.9.10-д заасан ААН-ийн нэгж нь Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлж болох энэ зохицуулалтаар шийдвэрлэгдэж болох юм шүү гэсэн ийм хариуг өгсөн юм. Тэгэхээр энэ тусгай сан дээр спортыг дэмжих сан байгаа. Тэгэхээр 22.9-ийнхөө дагуу ААНБ энэ санд хийчих юм бол энэ сангаасаа зарцуулах зарцуулалтыг нь бол тухайн салбарын сайдынх нь эрх мэдлийн хүрээнд байгаа учраас и-спорт руу оруулах боломжтой шүү дээ гэсэн санааг бол саналыг бол өгсөн юм байгаа юмаа. Тэрнээс илт эсэргүүцсэн зүйлгүй, дэмжээгүй санал бол биш. Өөр зохицуулалт байна аа гэж харсан утгаар оруулсан юм.

С.Бямбацогт: Болдын Уянга гишүүн тодруулчихъя.

Б.Уянга: Тэр олон улсын уул нь бол и-спортын энэ хөгжлийг маш ихээр дэмждэг хүн юм байгаа юм. Тэгээд зориулаад тэмцээн эд нарыг ч зохион байгуулж дэмжиж явлаа. Тэгээд энэ хуулийн төслийг нэлээн сайн хараад яаж ер нь төрийн бодлогоор дэмжих ёстой юм бол оо, олон улс нь яадаг юм бол оо гэдэг дээр судалсан учраас асуулт асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ажлын хэсгийн ажлын хэсэгт байлаа шүү дээ та тиймээ. Би таныг нэрийг нь сайн тогтоосонгүй ээ уучлаарай. Та тэр олон улсын туршлагауд яагаад ингээд л ерөөсөө хамгийн эхний хайлт, хамгийн эхний асуудал дээр л и-спортын татварын урамшуулалтай холбоотой энэ зохицуулалт олон улсад шинэ юмаа гэж ингэж гарч ирээд байдаг юм бол. Энэн дээр хариулт өгөөч?.

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Д.Сайханчулуун: Татварын ерөнхий газрын татварын удирдлага, олон улсын татварын газар Сайханчулуун. Олон улсад бол яг и-спортыг төрөөс юу татвараас чөлөөлсөн асуудлуудыг бид нар судлаад явж байгаа. Тэгээд яг тодорхой чөлөөлсөн чөлөөлдөг тогтолцоо байхгүй. Одоогийн бид нарын судалж байгаа улсууд дээр байхгүй байгаад байгаа. Бид нарын энэ оруулж байгаа хуулийн төсөл нь бол юу гэж байна вэ гэхээр энэ татвараас чөлөөлж байгаа биш хандивлагчдын татвараас юу хөнгөлж байгаа, хандивласан орлогынх нь дүнг нь хөнгөлж байгаа гэсэн ийм асуудлуудыг оруулж байгаа. Энэ дээр бол Татварын алба Сангийн яам бол байр суурь нэгтэй байгаа.

С.Бямбацогт: Хууль санаачлагч нэмж хариулъя.

П.Сайнзориг: Энэ өөрөө эргээд нөгөө төсвийн дундуур орлого бүрдүүлэхтэй холбоотой, орлого бууруулахтай холбоотой шийдвэр бол бага харьцангуй. ААНОАТ одоо ч хөнгөлөлттэй ААН эдлээд явж байгаа. Тэгэхдээ хуулийн төслийн үйлчлэх

хүрээг үйлчлэх цаг хугацааг бид нар хууль санаачлахдаа 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс гээд дагаж мөрдөхөөр зохицуулалт хийчихсэн. Тэгэхээр төсвийн жилийн дундуур янз бүрийн орлого бууруулах ч байдаг юм уу ийм сөрөг нөлөө бол байхгүй байгаа.

Ер нь бол Европын болоод зарим улс орнууд энэ и-спортын тодорхой спортын энэ чиглэлүүдийг илүү их боловсролын хөтөлбөртөө оруулж байгаа. Энэ одоо цахим тоглоомыг зохистой хэрэглэхээсээ гадна ер нь энэ цэрэг армийн дараагийн шатанд угаасаа энэ кибер аюулгүй байдал, дээрээс нь энэ тиймээ дроноор суурилсан гэдэг юм уу ийм зайнаас ашигладаг ийм зэвсэг техникүүд хэрэглэж байгаа учраас энэ чиглэлийн асуудлыг ч гэсэн боловсролын хөтөлбөртөө оруулаад явдаг. Цаад агуулга нь бас ер нь бол бас дараа дараагийн улс орных...

С.Бямбацогт: Баярлалаа. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуултаа асууя.

Л.Соронзонболд: Өдрийн мэнд. Энэ нөгөө олимпын төрөл болон олимпын биеийн төрлийн спорт болон тэгээд дээрээс нь и-спорт шатар гээд л нэмэх гээд байна л даа. Спорт бол маш олон төрөл байгаа шүү дээ. Тэгэхээр зөвхөн ингээд олимпын төрлийн спортын үндэсний шигшээ баг болон и-спорт шатар гээд бусад спортыг ингээд орхигдуулаад байгаа тиймээ. Энэний яг цаад бодлого нь яагаад ингэж ялгаатай ханддаг юм бэ гэдэг дээр нэг асуулт. Яагаад гэхээр и-спорт шатар ч гэдэг юм уу холбоо бол ингээд тодорхой хэмжээнд өөрсдийнхөө саналыг илэрхийлээд идэвхтэй гүйснээс болоод манай хууль санаачлагч жишээлбэл ингээд өөрчлөлт оруулж байна л даа энэ чиглэлээр. Тэгээд энэ бусад спортын холбоод нь яагаад хамрагдаж болдоггүй юм гэдэг асуудал үүснэ шүү дээ. Тэгэхээр энэ дээр манай яамныхан ер нь ямар бодлогоор ингэж ялгаатай хандаад байгаа вэ гэдэг дээр л асуулт асуух гэсэн юм.

С.Бямбацогт: Пүрэвжавын Сайнзориг гишүүн хууль санаачлагч хариулъя.

П.Сайнзориг: ААНОАТ-ын энэ заалтыг орох анхны тэр санаа зорилго гэдэг юм уу индейшийг нэг бас харж үзсэн. Ялангуяа зүгээр Монгол Улсын нэр хүндийг бас өргөж болдог. Ерөнхийдөө ОУОХ-нд бүртгэлтэй гэдэг юм уу даа энэ олимпын төрлийн спортыг дэмжих, багийн спортыг дэмжих чиглэлдээ энэ анх энэ зохицуулалт бол илүү түлхүү яригдаж байсан юм байна лээ. Энд пара олимп болон олимпын төрлийн спорт байгаа. Ингээд спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр 26 үндэсний шигшээ баг бүрдүүлсний 24 нь яг энэ олимпын төрлийн спорт байгаа. 2 нь л олимпын төрлийн бус буюу шатар и-спорт байж байгаа. Энэ дээр нэмээд одоо Засгийн газрын гишүүн маань бас асуудлыг ярьж хэлэх боломжтой. Тэгэхдээ ер нь зүгээр өнөөдрийн түвшиндээ бол нөгөө хөрөнгө мөнгө санхүүгийн хувьдаа л шахагдаж ийм хэмжээнд байдаг юм байна лээ. Бусад спортыг дэмжихгүй гэдэг агуулга бол Засгийн газар ерөөсөө гаргадаггүй юм байна лээ гэдэг зүйлийг бас хэлье. Тэгээд бас нэмэлтээр манай Бат-Эрдэнэ хариулчих.

Тэгээд гол асуудал яах вэ зүгээр зарим энэ хууль дээр бас үндэсний спортыг оруулж болоогүй юм уу? Ялангуяа одоо үндэсний багийн спорт бол тэр зарим гишүүдээс хэлж байна лээ л дээ. Нөгөө тэмээн поло ч байдаг юм уу, энэ бөх ч байдаг юм уу тиймээ ийм зүйлийг хамааруулж болохгүй байсан уу гэж байна лээ. Тэгээд миний хувьд одоогоор ямар ч байсан энэ үндэсний шигшээ баг бүрдүүлэх хэмжээнд

нь авч үзье гэдэг байдлаар хуулийн төслийг оруулж ирсэн. Тэгээд холбогдох Засгийн газрын яамны ТНБД-аар нэмэлт хариултыг өгүүлье ээ.

С.Бямбацогт: Ажлын хэсэг индрийн 4 дүгээр микрофон Бат-Эрдэнэ дарга хариулья.

Б.Бат-Эрдэнэ: Энхтүвшин гишүүний асуултад хариулья.

Соёл спорт, аялал жуулчлалын яамны ТНБД Бат-Эрдэнэ. Биеийн тамир спортын тухай хуулийн 23.3-аар ер нь бол Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын тив дэлхийн спортын тэмцээн наадамд оролцох үндэсний шигшээ баг спортын холбоо бүрдүүлж үйл ажиллагаа хариуцан зохион байгуулна гээд ингээд заагаад өгчихсөн байгаа. Мөн Сайнзориг гишүүн сая хэллээ. Олимп болон пара олимпын төрлийн спортод шигшээ баг нь бүрдэж байгаа гэж байна.

С.Бямбацогт: Баярлалаа. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуултаа асууя алга байна. Салдангийн Одонтуяа гишүүн асуултаа асууя.

С.Одонтуяа: Энэ ААНОАТ-ын тухай хуулийн энэ нэмэлт өөрчлөлтийг гишүүд санаачлан өргөн барьж байгаа юм байна. Яг энэ томьёоллынх нь хувьд бол энэ хуулийн төслийг дэмжиж байна аа. Ер нь бид бас энэ спорт хүүхэд залуучуудын бас ирээдүйн асуудал дээр төрийн бодлогоор ингээд дэмжээд явж байх нь маш зөв зүйтэй гэж үзэж байгаа учраас энэ хуулийг дэмжиж байна. Энэ хуультай холбоотой бас нэг зүйлийг бас энийг ташрамд хэлчихье гэж бодож байна.

Ер нь энэ татварын жилийн татвар ноогдох орлогын нэг хувь хүртэлх хэмжээнээс хэтрэхгүйгээр одоо энэ спортод мөнгө оруулахыг зөвшөөрч байна. Ялангуяа энэ агаарын бохирдлыг бууруулахад бас энэ 22.9.1 гэсэн заалт байгаа. Энэ заалт бол маш чухал заалт болсон. Яагаад гэхлээр улсын төсвөөс бид агаарын бохирдлыг бууруулахад төдийлөн мөнгө зарцуулж чадахгүй байгаа. Би өнгөрсөн бас нэг 6 сарын хугацаанд Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороон даргаар ажиллаж байхдаа яаж энэ ямар мөнгөөр бууруулах вэ гэхээр төсөв байхгүй. Тэгэхээр яг энэ мөнгөн дээр л бууж байгаа. Ингээд аж ахуйн нэгжүүдтэй уулзаад, ярилцаад дэмжүүлээд одоо нэг 6 орчим тэрбум төгрөгийг бид олоод энэ агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан юм. Маш олон сургуулийг газад шилжүүллээ. Автомашин дээр утаа хэмжигчийг тавилаа. Одоо утаа бууруулагч тавилаа гэх мэтчилэн. Тэгэхээр энэ бол бас нөгөө төсөв хөрөнгөд найдахгүйгээр өөрсдөө ААН-үүдтэй ярьж хийж болох энэ их чухал заалт орсон юмаа гээд би энэ хуулийг их зөв зүйтэй хууль гэж хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр би бол гишүүд маань уг нь одоо яг нөгөө утаа болохоор л гамшиг боллоо гээд бусад үед мартчихгүй. Уг нь гишүүд маань 1, 1 тэрбум төгрөгийг ААН-үүдтэй ярьж олоод л тэгээд л энүүгээрээ өөрийнхөө орон нутагт ч юм уу нэг сургууль цэцэрлэг, энэ агаарын бохирдлыг бууруулахад энэ мөнгийг нь зарцуулчихвал хууль нь байгаа юм л даа. Тэгэхээр энийг бас гишүүдийг би бодооч ээ гээд би бас яах вэ албан бичгээр та бүхэнд хүсэлт өгнө өө гэж бодож байна.

Нэг асуулт байна. Татварын ерөнхий газрынхан хариулах уу? Энэ ер нь энэ 2025 оны дүнгээр энэ нэг хувьд хэчнээн төгрөг ААН-үүд ер нь зарцуулсан ийм дүн тооцоо байна уу? 2025 онд. Ер нь хэр их мөнгө яг энэ хөнгөлөлтөд хамрагдсан юм бол оо? Энийг асуух гэсэн юм. Тэгээд ер нь бол энэ хууль их чухал хууль. Ялангуяа

спортын чиглэлд олон юманд яаж байна. Одоо энэ хөрсний бохирдол, усны бохирдол гээд ингээд. Тэгэхээр энэ чиглэлээр бид нар маш их зүйлийг хийж болох энэ гарц гаргалгааг нь гаргачихсан юмаа энэ хуулиар гэдгийг л бас хэлэх гэсэн юмаа. Хуулийг бол үзэл баримтлал бүх юмыг нь дэмжиж байгаа.

С.Бямбацогт: Татварын Ерөнхий газар ажлын хэсэг хариулъя.

Б.Буяннэмэх: Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Буяннэмэх. Гишүүний асуултад хариулъя. Агаарын бохирдолтой холбоотой буюу 22.9.1-ээр 2025 оны жилийн эцсийн тайлангаар 22 хуулийн этгээд 26.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлт эдлэхээр тайлан ирүүлчихсэн байж байна аа. Нийтдээ ер нь 304 аж ахуй нэгжийн 103.9 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт эдлэхээр тайлан ирүүлчээд байна Татварын албанд.

С.Бямбацогт: Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн асуултаа асууя.

М.Ганхүлэг: Асуултууд ер нь давхардаж байна аа. Ерөнхий хуулийн төслийн асуудлыг дэмжээд явна юу саналыг дэмжээд явна аа. Тодруулах бас хэд хэдэн зүйлүүд байна. Ер нь бид хэд энэ бас хуулийг баталж хэрэгжүүлснээс хойш салбаруудаар нь дахиад дэлгэрүүлээд нэг танилцуулаад өгөөч? Аль аль чиглэл дээр ААН-үүд маань илүү гол анхаарлаа хандуулаад явж байна вэ гээд. Энэ дээр бас тавьж байгаа хяналт байдаг юм уу, тодорхой бас гарч байгаа үр дүн дээр цаашид анхаарахтай холбогдолтой ямар зөвлөмж саналууд бас гарч байна вэ? Энийгээ бас илүү сайжруулаад явах тал нь гол анхаарлаа хандуулаад явах нь зөв өө гэсэн ийм бодолтой бас байна. Эхний асуулт нь.

2 дахь нь өнгөрсөн Соёл спорт залуучуудын дэд хорооны бас ахлагчаар ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бас хэд хэдэн хэлэлцүүлгүүдийг зохион байгуулаад ажилласан. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд мөн дээрээс нь спортын холбоод тэр дундаа үндэсний спортынхон бас болон энэ дугуйлан секцүүд ажиллуулж байгаа энэ клуб энэ чиглэлийн бизнес эрхэлж байгаа бас хүмүүс бас тэгэхдээ бас уулзах уулзалтыг бас зохион байгуулсан. Энэ хэлэлцүүлгийн хүрээнд ирсэн тодорхой саналыг бас хууль санаачлагчдаас бас асууя гэж бодож байна. Зөвхөн одоо и-спорт гэлгүйгээр илүү өргөн хүрээнд харах гэж бас гишүүд маань асууж байна. Энэ дээр тодорхой хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг оруулаад бас явах ийм боломж бололцоо байгаа юу?

Ялангуяа үндэсний спортын төрлүүдийг яах вэ гэдэг дээр бас маш их саналууд бас энэ хэлэлцүүлэг дээр ирсэн. Манай гишүүд рүү бас саналуудаа хэлээд явж байгаа байх. Монгол үндэстнийхээ энэ бас спортыг дэмжих чиглэл дээр тодорхой бас энэ нэг хувийн зохицуулалтуудыг хийгээд явах нь зөв юмаа гэсэн ийм байр суурьтай бас байгаа. Дээрээс нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд бол олимпын төрөл дээр нь пара олимп гэдгээр нь ингээд хязгаарлачхаад байгаа юм. Гэтэл яг одоо бас нөгөө спортоор хичээллэх өөрсдөө бас эндээ анхаарах чиглэл дээр зайлшгүй төр бол анхаарах ёстой юу гэвэл анхаарах ёстой. Мөн ААН-үүд бас энийг дэмжье гэдэг ийм хүсэлтүүд тавингуут нөгөө журам энэ юунуудад нь төрлүүдэд нь байхгүй байна аа гээд. Тэгээд энийг та хэд дэмжээд өгчихвөл дэмжих ААН-үүд байгаад байна гэдэг ийм саналыг бас уламжилж байна аа. Тэгэхээр тусгай олимп нөгөө сонсголгүй бас иргэдийн олимп энэ марафон гүйлтүүд нь нийтийн. Тэгэхээр эдгээр бас энэ ашгийн бус энэ чиглэлээр бас ажиллаж байгаа энэ

мэргэжлийн холбоодыг бас дэмжих чиглэлийн агуулгыг өргөн хүрээнд оруулж ирээд бас яривал яасан юм бэ гэсэн ийм саналууд бас байна.

3 дахь нь ХАА-н салбараас бас ирж байгаа юм. Сум орон нутаг дээр хоршоо болоод янз бүрийн одоо энэ ЖДҮ-лэл эрхлээд явж байгаа бас иргэдийн хувьд томоохон бас энэ бэлтгэн нийлүүлж байгаа ААН-үүд рүүгээ анхан шатны бэлтгэн нийлүүлэлтээр ажиллаж байгаа энэ төслүүдийг нь дэмжээд ингээд уялдаа холбоог нь хийгээд явах ийм бодитой бас саналууд бас байна аа. Тэгэхээр энэ баялаг бүтээж байгаа хоршоологчид, ЖДҮ-лэл эрхлэгчдийг дэмжих чиглэл рүү энэ ААН-ийн орлогын албан татварын нэг хувийг чиглүүлэх гэсэн иймэрхүү өргөн хүрээтэй асуудлыг бас нэг 2 талаас нь хэдүүлээ хэлэлцүүлгийн түвшинд жоохон задлаад ярих боломжтой юу? Ингэвэл тодорхой асуудлууд нь бас гол нөгөө нэг юу зорилгоосоо одоо хазайгаад олон асуудал руу ороод ингээд явах ийм эрсдэл гарах уу? Өмнөх жилийн тайлан мэдээлэл дээр ингээд харахад энэ нэр төрлүүд дээр хасаж, нэмэх тал дээр тодорхой дүгнэлтүүд гарсан уу гэдэг ийм ерөнхий агуулгуудаар бас асуулт асууя. Татварынхан бас энэ дээр

С.Бямбацогт: Хууль санаачлагч Пүрэвжавын Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Манай татварынхан бас хариултуудад бэлдээч ээ гэж хүсэж байна. Ер нь зүгээр яах вэ хуулийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр зүгээр олимп болон пара олимп тэгээд ҮОХ-ны гишүүн холбоотой энэ л асуудлыг зохицуулчихсан ингээд байж байгаа. Энэ хүрээн дээр яах вэ Засгийн газрын гишүүний шийдвэртэй үндэсний шигшээ багуудыг хамруулъя гэж байгаа. Энэ дээр бол тооны хязгаар байхгүй. Үнэхээр боломж нь байвал спортыг дэмжих чиглэлтэй бас тодорхой спортын төрлүүдийг хамруулаад явах бололцоо байх юм байна лээ, байх юм байна лээ. Хууль дээр хязгаарлалт бол байхгүй. Зүгээр энэ дээр нөгөө үндэсний спортын асуудлыг бас бид хэд зайлшгүй анхаарах зайлшгүй шаардлага байгаа.

Ер нь зүгээр Биеийн тамир спортын тухай хуулиасаа гадна үндэсний спортын тухай хуулийг бие дааж гаргаад, энийг өв соёл, спортын тэр тиймээ талаас нь ингээд эргээд бид хэдийн хүүхэд залуучуудын бас бие бялдар ч гэдэг юм уу энэ монгол ахуйгаа авч үлдэх талаас нь бас бид хэд зайлшгүй бие даасан хуультай гаргаж, энэ өөрөө бас аялал жуулчлалын томоохон бүтээгдэхүүн харагдаад байгаа юм. Тэгэхээр энийг зайлшгүй бодлогоор дэмжих ёстой. Тэгээд бас Ганхүлэг гишүүндээ болон Одноо гишүүн хоёртоо бас баярлаж байна. Энэ татварын хуулийн энэ асуудал бол цэвэр ААН татвараа төлөхөөсөө гадна нийгмийн энэ сайн сайхан гэдэг юм уу, нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой үйл ажиллагаанд биечилж оролцох, биечлэн одоо юу гэдэг юм асуудал дээрээ хяналт тавиад оролцох энэ бололцоог нь бүрдүүлж байгаа юм байна лээ.

Тэгэхээр татвараа өгөөд миний татвар спортыг дэмжиж байгаа байх гээд найдаад орхих биш яг тодорхой зүйлээ спорт руу ингээд оруулаад явах бололцоог нь олгосон, эсвэл байгаль орчинд оруулах бололцоог нь олгосон ийм асуудал байгаа. Тэгээд спортын хувьд бол энэ хууль дээр хэлэлцэхийг дэмжсэн тохиолдолд анхны хэлэлцүүлэг дээр саналууд гаргаад явахад боломжтой. Өөрөөр хэлэх юм бол спортын болоод татварын бодлогыг Улсын Их Хурал тодорхойлж байгаа. Тийм учраас гишүүдийн бүрэн эрхт бол байгаа. Харин таны сүүлийн асуудал буюу ЖДҮ-лэлийг дэмжих чиглэлд энэ татварын нэг хувийг оруулах гэдэг асуудал дээр миний энэ удаагийн хуулиар хөндөөгүй ээ. Тийм учраас энэ асуудлыг хөндөж ярих

бололцоо хууль зүйн техникийн хувьд болоод дэгийн хуулийн дагуу байхгүй ээ. Энэ дээр тусдаа явах ёстой.

Тэгээд ер нь зүгээр энэ спортыг дэмжиж, спортыг эдийн засагжуулах замаар хүүхэд залуучууддаа зөв нөлөө үзүүлэх, энийгээ дагасан ер нь хэд хэдэн хуулийг бас санаачилъя гэж бодож байгаа. Морин тойруулгын хууль байна, спорт, бетийн хуулийг зөвхөн үндэсний спортоо дэмжих чиглэл рүү нь бас оруулж боловсруулалтыг хийе гэсэн ийм байдалтай ингээд бас явж байгаа гэдэг зүйлийг хэлье. Тэгээд ийм зүйл рүү бид нар бас хөрөнгө оруулалт хийж чадвал ирээдүйд учрах тэр том эрсдэл, гэмт хэрэг зөрчлийн хохирогч болох эсвэл гэмт хэрэг зөрчих гаргагч этгээд болох ч гэдэг юм уу эсвэл олон энэ нийгмийн энэ эрсдэлүүдээс бид нар хүүхэд залуучууддаа бас урьдчилан сэргийлж хамгаалж чадах юмаа гэдэг л энэ концепцоор одоо явж байгаа гэдэг зүйлийг хэлье. Тэгээд таны энэ саналуудыг бас хэлэлцээд явах боломжтой гэж үзэж байна аа. Ингээд татвараас нэмээд яачих уу?

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Б.Буяннэмэх: Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Буяннэмэх. Гишүүний асуултад хариулъя. Мэдээж 22.9-тэй холбоотой бол ингээд 11 заалт байгаа. 11 заалтаар энэ заалт болгоноор нь яах юм бол байгаль орчин хамгааллын юугаар бол 21 татвар 22.9 тэрбум, ахмад настны хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 25 татвар төлөгчийн 1.8 тэрбум төгрөгийн хөнгөлөлт, соёлын өвийг хамгаалах сэргээх дээр 27 татвар төлөгчийн 22.7 тэрбум төгрөг, нийтийн эзэмшлийн зам талбай, цэцэрлэгт хүрээлэн барьж байгуулах дээр 12 татвар төлөгчийн 2.8 тэрбум төгрөг, гамшигт давтагдашгүй хүчин зүйлээр нэг татвар төлөгчийн 10 сая төгрөг, соёлын, спортын барилга байгууламж Монголын үндэсний олимп үндэсний пара олимпын хороонд бүртгэлтэй 157 буюу 43.8 тэрбум төгрөгийн, Засгийн газрын зарласан тэргүүлэх чиглэлийн гадаад, дотоод, их, дээд сургууль...

С.Бямбацогт: Баярлалаа. Мэндбаярын Мандах. Ганхүлэг гишүүн тодруулж асууя. Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн.

М.Ганхүлэг: Хэлэлцэх эсэхийг нь дэмжээд бас үндэсний өв соёл спорттой холбогдолтой асуудлаа бас оруулаад явах нь бас зөв болов уу гэсэн ийм саналтай байна. Ер нь бол бас Монгол түмний ондоочлолтой холбогдолтой зөвхөн морь, бөхөөс гадна бусад төрлийн одоо бас энэ үндэсний спортуудыг өргөн хүрээнд бид нар дэмжих ийм хэрэгцээ бас бидэнд байгаа гэсэн ийм байр суурьтай байгаагаас бас хэлье ээ. Тэр гаальтай холбогдолтой асуудал дээр и-спорт дээр бас нэг асуумаар санагдаад байгаа юм. И-спортын тамирчдын тэр тоног төхөөрөмж гэдэгт нь тэр компьютер тоног төхөөрөмжүүдийг оруулж тооцох юм уу? Энэ дээр та хэд маань яаж харж байгаа вэ? Тэгэхээр нөгөө нэг бас үүний цаана бас өөр янз янзын асуудлууд бас үүсчих вий. Тэгэхээр энийг яаж харсан бэ гэдгийг асуучихъя.

С.Бямбацогт: Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Энэ гааль, НӨАТ-ын асуудал дээр бол нөгөө Биеийн тамир спортын тухай хуулийн 10.1.1-д заасны дагуу байгуулсан үндэсний шигшээ баг гэхээр 26 үндэсний шигшээ багийн асуудлыг л хамруулж байгаа. Яах вэ зүгээр и-спортын асуудал нэг компьютероор шалихгүй дээ нэг хэдэн компьютер л гэх. Ер нь зүгээр энэ жишээ нь би бейсболын холбоотой бас илүү нягт холбоотой ажилладаг.

Энэ холбоо бол санхүүгийн хувьд ч гэсэн бас хүндрэлтэй л байхгүй юу. Гэтэл одоо Японы нэг ийм хандивлагч иргэнээс маш олон зүйлүүдийг хүүхэд залуучуудад үнэгүй явуулдаг. Гааль, НӨАТ-аа төлж авч чаддаггүй ингээд л хаягдчих. Тэгээд эцэг эхчүүдээс нь ч гэдэг юм уу сайн санаат ААН байгууллагуудаас л хандив тусламж гуйгаад л ингээд нэг НӨАТ, гаалийн татвар төлөлцөөд өгөөч гээд явдаг. Хэлэлцүүлгийн юу ч гэсэн Булгантуяа дарга хэлж л байна лээ. Дугуй спортынхон дугуй шагналдаа авсан чинь энэ дээр гааль татвар нь бараг хэдэн саяын үнэтэй дугуй байна гээд тийм өндөр хэмжээний гааль татвар нэхээд суучихдаг, авч чадахгүй гэх зэрэг одоо энэ бас спортын гэдэг юм уу, үндэсний шигшээ баг бүрдүүлсэн энэ спортын шигшээ багуудад ер нь нийтлэг тулгамддаг энэ асуудлыг хамруулъя л гэж байгаа юм. Зөвхөн энэ...

С.Бямбацогт: Тодруулчихсан уу? Дахиад Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн тодруулъя.

М.Ганхүлэг: Тийм яг одоо и-спортын чиглэлээр энэ компьютерыг оруулж ирж байна аа гэдэг дээр нь яаж ер нь зохицуулах юм бэ л гэж асуугаад байна л даа. Бусад бас дэлгүүр хоршоодууд бас энэ тодорхой боломжийг ашиглаад бас ингээд явчих ийм боломж бас гарах уу? Гаалийнхан энэ дээр тодорхой бас ямар зохицуулалтаар оруулж ирдэг юм бэ гэдгийг бас тодруулаадахъя.

С.Бямбацогт: Тийм, хууль санаачлагч хариулахдаа болохоор нөгөө шагнал давсан компьютероо юу тэр юу гэдэг юм тиймээ шагналын тоног төхөөрөмжөө байж болно гээд байдаг. Гэтэл нийтлэгээр нь хавтгайруулчих юм биш үү л гээд асуугаад байна шүү дээ. Хавтгайруулахгүй байх үндэслэл байна уу? Заавал ингэх хэрэгтэй юу бас тийм. За Сайнзориг гишүүн хариулъя.

П.Сайнзориг: Энэ боломж жишээ нь гаалийн хууль дээр ч байгаа л даа. Ерөнхийдөө спортын тоног төхөөрөмж гээд нийтлэг байгаад байгаа юм. Тэгэхээр энийг нь хэрэгжүүлэх асуудал ерөөсөө практик дээр байхгүй. Тэгэхээр энийг илүү их зүгээр энэ хуулиар тодруулаад, яг үндэсний шигшээ баг бүрдүүлсэн буюу 26 энэ багийг хамрагдах тэр спорт холбооны тодорхойлолт болон энд зориулалтаар ашиглаж байгаа. Энэ нь өөрөө эргээд тухайн байгууллага дээр бүртгэж ашиглагдах ёстой. Хандив тусламжийг зориулалтын дагуу ашиглагдах энэ нь өөрөө нягтлан бодох бүртгэлийн юугаараа бас нотлогдох боломжтой. Дараа нь татвараас зайлсхийсэн янз бүрийн юм байх юм бол тусдаа хариуцлагын асуудалтай ийм л зүйл байгаа.

Тэгэхээр ер нь зүгээр яах вэ и-спортыг гэдэг л асуудал нь байгааг тодотгож байгаа болохоос бусад спортын холбоод бол бас л энэ чиглэлийн проблем юмнууд нийтлэг байгаа гэдэг зүйлийг хэлмээр байна. Тэгээд зөвхөн юу гэдэг юм бэ дээ энэ яамны нэг тодорхойлолтыг хараад бас энэ суугаад байдаг юм байна лээ. Уг нь бол энэ журмыг маш тодорхой болгоод өгчихвөл спортод өгч байгаа энэ зүйлүүд бол дандаа хүүхэд залуучууд байдаг ийм л зүйл байгаа. Эндээс нэг...

С.Бямбацогт: Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууя алга байна. Цэндийн Баатархүү гишүүн асуултаа асууя алга байна. Отгоны Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Баярлалаа. Би сангийн болон татварын чиглэлийн хүмүүс ирчихсэн байгаа учраас тодруулж бас асууя гэж бодож байна. Манай улсад одоо

байгаа үндэсний шигшээ баг ер нь шигшээ баг мөн спортын холбоод яаж үүсгэн байгуулж бүртгэж авдаг юм бэ гэдэг процессыг сонирхож байна. Яагаад гэвэл хүмүүс хэн дуртай нь холбоо байгуулаад тэгээд ингээд орчихдог юм уу яаж бүртгэдэг юм гэдэг асуудал.

2 дугаарт нь тусгай сан буюу спортын сангаас яаж дэмжлэг авдаг юм. Одоо жишээлбэл нэг холбоо байгуулаад нэг шигшээ баг бүрдлээ гэхэд тэр санхүүгийн дэмжлэг авдаг процессыг жоохон ойлгомжтой тайлбарлаад өгөөч ээ гэдгийг бас тодруулмаар байна. Өөрөөр хэлбэл спортын холбоог бүртгүүлэх замнал ер нь ямар шаардлага тавьдаг юм, ямар дүрэм журамтай байдаг юм гэдгийг тодруулмаар байна.

3 дугаарт нь спортын сангийн зарцуулалтыг харах юм бол илүү тэмцээн уралдаан руу чиглэж байна уу эсвэл нийтийн биеийн тамираа дэмжих агуулгаар яваад байна уу? Өөрөөр хэлбэл спорт гэдгээ ер нь юу гэж ойлгоод байна тиймээ. Ер нь энэ улсаа сурталчлах агуулга гэж ойлгодог юм уу эсвэл хүмүүсийг эрүүл мэндийн хувьд илүү идэвхтэй аливаа зүйлээс өөрийгөө өвчнөөс урьдчилан сэргийлдэг тэр хөдөлгөөн талаас нь ойлгоод байна уу гэдэг ялгааг бид нар юу гэж харж байгааг харах хэрэгтэй байгаад байна. Тэгээд мөн нэмэгдээд ер нь тэр одоо нэг хувийн зарцуулалтыг түрүүн дурдана лээ дээ. Тэрэн дээр би илүү тодруулмаар байгаа юм. Спортын хэсгийн зарцуулалт дээр юу юу байна гэдгийг задалъя. Яагаад гэвэл спортын барилга байгууламж гэдэг дээр орчихсон байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь бол хэн дуртай нь спортын барилга байгууламж гэдэг бол маш том хэмжээний газар шаарддаг, материал барилга шаарддаг зүйл.

Тэгэхээр хэн тэр спортын барилга байгууламжийг барихад одоо чадалтай вэ гэдгээ харахаар бид нар ойлгомжтой. Тодорхой хэдэн томоохон ААН байгууллагууд байгаа. Тэгэхээр эргээд энэ хөнгөлөлт маань нэг хувийн хөнгөлөлт маань өөрөө хэнд зориулагдсан бэ гэдгийг бид нар бас ялгаж хармаар байгаа. Гэтэл өнөөдөр Улаанбаатар хотод маш олноороо уг нь сүүлийн үед нэлээн дэлгэрч байгаа нь фитнес, жим тиймээ, иог бүжгийн спорт энэ тэр дээр ер нь улсаас ямар дэмжих бодлого байдаг юм бэ? Одоо оффис байдаг юм уу, түрээс байдаг юм уу, татвар байдаг юм уу тэд нарын хувьд ер нь ямар санхүүгийн дэмжлэг байна вэ гэдэг зүйлүүдийг мэдээлэл аваад тэгээд би тодруулъя.

С.Бямбацогт: Сангийн яам. За Соёл спорт, аялал жуулчлалын яам. Ажлын хэсгийн 4 дүгээр микрофон Бат-Эрдэнэ дарга хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Олимп болон пара олимпын холбоонд бүртгэлтэй байгаа бүртгэгдсэнээр үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүн бүрддэг.

С.Бямбацогт: Хариулт хангалтгүй л байна даа. Тодруулж асуух уу? Отгоны Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Спортын сангаас яаж дэмжлэг авдаг юм бэ л гэж асуугаад байгаа байхгүй юу. Шигшээ баг болон спортын холбоод яаж дэмжлэг авдаг юм. Олимпод бүртгэлтэй болохын тулд ямар замыг дамждаг юм бэ гэдгийг бас тодруулаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл одоо спорт чинь маш их глобал болж байна. Олон төрлийн спорт бий болж байна шүү дээ тиймээ. Тэгэхээр энэ бүртгүүлдэг тэр зам, тэр холбоо байгуулах процесс яаж явдаг юм, бүртгүүлээд

байгууллаа гэхэд спортын сангаас яаж дэмжлэг авдаг юм бэ гэдгийг тодруулмаар байгаа байхгүй юу. Тэр процессыг нь тайлбарлаад өгөөч?

С.Бямбацогт: 4 дүгээр микрофон ажлын хэсгийн.

Э.Билэгт: Биеийн тамир, спортын улсын хороо Билэгт. Спортыг дэмжих сан бол Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын баталсан журмаар санхүүжүүлнэ. Сүүлийн жилүүдэд улсын төсөв дээр спортыг дэмжих сан дээр төсөв байхгүй учраас санхүүжүүлээгүй ийм байдалтай байгаа. Шигшээ баг бүрдүүлэхдээ бол Монгол Улс МҮОХ-нд бүртгэлтэй спортын холбоод Монголын пара олимпын хороонд бүртгэлтэй спортын холбоодтой бид бүхэн гэрээ байгуулж санхүүжүүлдэг ээ. Энэ нь Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар шалгуур үзүүлэлт гэж сайдын баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүжүүлдэг байгаа. Олимпын хороо ОУОХ олон улсын паралимпын хороо бол Монгол Улсад ганц төлөөлөх байгууллага нь МҮОХ, Монголын үндэсний пара олимпын хороо 2 байдаг учраас ийм зохицуулалттай байдаг аа.

С.Бямбацогт: Отгоны Саранчулуун гишүүн тодруулж асууя.

О.Саранчулуун: Нэг хувийн татварын асуудлыг ярьсан тиймээ. Тэгэхээр түрүүн нөгөө жагсаалт гаргасан шүү дээ. Нэг хувийн татварын хөнгөлөлтөөр спортод зориулж мөнгө гарсан байна аа. Маш сайн хэрэг. Одоо тэр мөнгөө хэдүүлээ ангилж байгаад ямар ямар чиглэлд гарсан юм бэ. Тэмцээн уралдаан байсан юм уу, барилга байшин барьсан юм уу тиймээ эсвэл одоо нийтийн биеийн тамираа дэмжих агуулгатай байсан юм уу гэдгээ хэдүүлээ тодруулж харах хэрэгтэй болоод байна. Яагаад би ингэж асууж байгаа вэ гэхлээр бид нар биеийн тамир спортыг дэмжинэ гэдэг бодлоготой мөртөө тамирчдыг дэмждэг байхгүй юу. Би тэрийг үгүйсгээгүй. Гэхдээ нийтийн биеийн тамираа дэмжинэ гэдэг чинь, спорт дэмжинэ гэдэг чинь зөвхөн тамирчин тэмцээн уралдаанд явах асуудал биш байхгүй юу. Хүн өдөр болгон 7 хоногт 1-2, 3 удаа дасгал хийх эрүүл байх асуудал байгаа. Нийгэмших асуудал байгаа, сэргээн засах асуудал байгаа. Тэгэхээр энийг бид нар ер нь биеийн тамир гэж хардаг юм уу, үгүй юү. Одоо байгаа жим, иог гээд төвүүдэд ер нь татвар санхүүгийн дэмжлэг байна уу, үгүй юү гэдгийг бас тодруулах гээд байна шүү дээ. Энийг бас нэмээд хариулах хэрэгтэй байна.

С.Бямбацогт: Индрийн 4 дүгээр микрофон ажлын хэсэг хариулъя.

Б.Буяннэмэх: Татварын ерөнхий газрын татвар төлөгчид үйлчлэх газрын дарга Буяннэмэх. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 22.9.6-тай холбоотой би энэ түрүүн нэгдсэн дүнг нь хэлсэн. Энэ дотроо ингээд спортын төрөл, спортын барилга байгуулах соёлын өвийг хамгаалах гээд ингээд байгаа. Тэгэхээр таны хэлсэн асуусан юман дээр спортын төрлийг дэмжих дээр өнөөдөр 132 ААН 24.6 тэрбум яг энэ дотроо, спортын барилга байгуулах нэгж дээр 20 ААН 26.7 тэрбум төгрөг байна. Дотор нь спортын төрлийг нь үзэх юм бол олимпын энэ одоо хууль тогтоомжид заасан шаардлагынхаа хүрээнд олимпын спортын төрлийн багт байгаа ийм асуудлаар л хөнгөлөлт чөлөөлөлтийг нь тайлбар ирүүлчхээд байгаа. За баярлалаа.

С.Бямбацогт: Өлзийхүүгийн Шижир гишүүн. 2 удаа тодруулчихсан байх аа тийм. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуултаа асууя алга байна. Сая хэний Саранчулуун гишүүний асуулт хариулт хангалтгүй байгаад байгаа учраас дахин

дахин тодруулаад байна. Тийм болохоор Саранчулуун гишүүний сая хөндсөн асуултуудад хариултуудыг та бүхэн бичгээр ирэх 7 хоногт багтааж хүргүүлээрэй. Хангалттай сайн мэдээлэл, хууль зүйн үндэслэл тайлбар бүх мэдээллийг хүргүүлээрэй.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хангалттай хариулж чадахгүй бол бичгээр хариулах ийм бас хуультай шүү. Тийм болохоор ирэх 7 хоногт багтаагаад Саранчулуун гишүүний асуултад та бүхэн бичгээр хариулт өгөөрэй гүйцээж. Мөн Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүний асуултад бас хангалттай хариулж чадаагүй гэж үзэж байна. Тийм болохоор бичгээр хариултуудыг бас гүйцэж өгөөрэй.

Банзрагчийн Түвшин гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Мэндбаярын Мандхай гишүүн асуултаа асууна уу, үгээ хэлнэ үү? Алга байна. Отгоны Саранчулуун гишүүн үг хэлнэ. Индрийн 1 дүгээр микрофон.

О.Саранчулуун: Спорт гэдэг бол зөвхөн тодорхой хэдэн тамирчдын эсвэл тодорхой хэдэн хүмүүсийн асуудал биш. Энэ бол нэг нийгмийн соёлын асуудал. Спорт мөн зарим хүмүүсийн хувьд сэргээн засах ийм нийгмийн маш чухал бас нэг хэрэгсэл. Нөгөө талдаа спорт бол нийгмийг соён гэгээрүүлж байдаг. Хүмүүсийг эрүүл мэндийг нь хамгаалж байдаг ийм зүйл байгаа. Тэгэхээр бид нар спорт гэдгийг харахдаа нийтийн биеийн тамир гэдэг агуулгаар нь томоор харах хэрэгтэй байгаа. Ихэнх тэмцээн уралдаан эсвэл олимп шигшээ багийн тамирчдад дэмжлэг үзүүлээ гэдэг ААН-ийн тайлан мэдээллүүдийг бид нар хардаг боловч яг үнэндээ өдөр тутмынхаа амьдралд спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалж байгаа хүмүүсийг дэмждэг нийгмийн эрүүл мэндийн бодлого бид нарт дутагдаж байгаа гэсэн үг.

Монгол Улсад өнөөдөр маш олон фитнес жим хүүхэд залуучуудыг уриалж байгаа ийм спортын байгууллагууд олноороо бий болж байна. Маш олон марафон гүйлтийн тэмцээнүүд зохион байгуулагдаж байгаа. Энэ болгон дээр бид нар бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Ингэх юм бол бид нар өнөөдөр жил болгон дэлхийд тэргүүлж байгаа энэ хорт хавдар, эрүүл мэндийн эрсдэлтэй өвчин эмгэг тиймээ нас баралт өндөр байгаа өвчний тархалт маш их тэргүүлж байгаа асуудлуудаа бид нар бууруулж чадна. Тэрнээс биш бид нар эмнэлэг барих юм уу эсвэл эм, эмнэлгийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөр бид нар хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалахгүй ээ.

Монгол Улс Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуультай болоод 2 жил, 3 жил болох гэж байгаа. Гэсэн хэдий ч нийгмийн эрүүл мэнд нийтийн эрүүл мэнд дотроо бид нар спорттой бие нийтийн биеийн тамираа дэмжих агуулга нь маш сул байсаар байгаа. Тэгэхээр энэ дээр салбар дундын асуудал гэж ойлгоод эрүүл мэнд гэдэг асуудал нийтийн эрүүл мэнд гэхлээр зөвхөн ЭМЯ хариуцах ёстой эсвэл нийтийн нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн хариуцах ёстой гэдэг агуулгаас биш бүх төрлийн спортыг ялангуяа биеийн эрүүл мэндийг дэмжсэн спортыг бид нар бодлогоор дэмжих хэрэгтэй байгаа. Сургуулиудад бид нар биеийн тамирын

хичээлийг маш өндөр олон сонголттойгоор зохион байгуулалттайгаар оролцуулах хэрэгтэй. Хүүхдүүдээ багаас нь биеийн тамираа хамгаалахын тулд биеийн тамирын багш нараа дэмжих хэрэгтэй. Биеийн тамирын спортыг дэмжиж байгаа, эхлүүлж байгаа бүх байгууллагуудыг бид нар бодлогоор, татварын бодлогоор, нийгмийн хариуцлагынхаа хүрээнд ААН-үүд дэмжих хэрэгтэй байгаа.

Одоо байгаа нэг хувийн татварын хуулийн зарцуулалтыг харахаар спортын барилга байгууламж гэж байна. Дундаж хэмжээтэй жим жижиг хэмжээтэй ААНБ спортын барилга байгууламж барих чадал байхгүй ээ. Тийм бололцоо байхгүй. Харин тэр эхлээд 10 ч болтугай сумандаа ч юм уу, аймагтаа тиймээ 10, 20 ч болтугай хүмүүсийг биеийн тамираар хичээллүүлээд, фитнесээр хичээллүүлээд гүйлтийн зам дээр алхуулж байгаа тэр жижиг аж ахуйн нэгжийг бид нар дэмжиж байж өнөөдөр бид нар энэ биеийн тамирыг дэмжиж байгаа гэж ярих хэрэгтэй болно. Тэрнээс биш тодорхой хэдэн хүмүүсийн замын зардал тэмцээн уралдааныг дэмжихээд Монгол Улсын биеийн тамир дэмжиж байна аа, болж байна аа гэдэг агуулгаар ярьж болохгүй гэдэг санааг бас та бүхэнд хэлэхийг хүсэж байгаа.

Тэгээд дээрээс нь одоо энэ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс байна. Хүнд өвчтэй хүмүүс байгаа. Энэ хүмүүс нийгмийн амьдралд эргэж орох хамгийн чухал нэг хэрэгсэл бол спорт байгаа. Зөвхөн халамж биш эсвэл сэргээн засах биш спорт өөрөө сэргээн засахын хэрэгсэл болдог. Гэтэл гаалиар гаалийн татвар дээр болон спортын хэрэгсэл тоног төхөөрөмжөө Монголд авчраад энэ дасгалаа хийх гэхээр орчин нөхцөл дутмаг байгаа. Хүмүүс гүйгээд алхдаг байя гэхлээр зам нь хангалттай биш байна. Нэг гүйлтийн клуб байгуулаад бүгдээрээ нэг газар цуглараад бэлтгэл хийхлээр заал нь үнэтэй байгаад байдаг тиймээ.

Тэгэхээр энэ бүх зүйлээ бид нар цогцоор нь харж байж өнөөдөр Монгол Улс биеийн тамир спорт гэдэг бодлогоо ярих цаг нь болжээ гэдгийг би та бүхэнд хэлэхийг хүсэж байгаа. Хуулийн төслийг дэмжиж байна. Цаашдаа хуулийн дараа дараагийн хэлэлцүүлэгт ажлын хэсэгт нь орж ажиллаж, энэ агуулгыг илүү дэлгэрүүлэх ийм хүсэлтэй байна аа. Баярлалаа.

С.Бямбацогт: Баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж, Цагаанчулуут багийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхнийхээ ажилд нь амжилт хүсье. Амьдралд нь эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэе. Манай Батлут сайд хамтдаа бас иргэдтэй Төрийн ордонтой танилцуулаад явж байна аа.

Пүрэвийн Батчимэг гишүүн үгээ хэлье алга байна. Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт бас ирц багатай байна аа.

Энэ татварын хөнгөлөлт чөлөөлөлт нэг хувийн хөнгөлөлт чөлөөлөлтийн хууль монголын бас биеийн тамир спорт сонирхдог залуучууд Монгол Улсын спортын хөгжилд ялангуяа сагсны спорт, волейболын спорт зэрэг бас лигийн тоглолттой спортуудын хөгжилд бас чухал хувь нэмрээ оруулсан, оруулж байгаа. 2024 оны 8 сард Засгийн газар энэ спортыг дэмжиж байгаа ААН-үүддээ нэг хувийн татварын хөнгөлөлт өгөх ийм хуулийг санаачилж Их Хурлаар батлуулсан. Энэ батлуулсан хуулийн хүрээнд өнгөрсөн 2 жилийн хугацаанд спорт олимпын төрлийн спортууд Монгол Улсад маш эрчимтэй хөгжиж байгаа. Энэ дотор бас орхигдсон и-спортоор дэлхийд бас манай монгол залуучууд нэр алдраа гаргаж, Монгол улсыгаа

сурталчилж үнэхээр одоо бас ямар мундаг чадвартайгаа харуулж байгаа. Гэтэл и-спортын төрөл маань энэ татварын нэг хувийн хөнгөлөлтөөс хоцорсон байсан учраас Сайнзориг нарын гишүүд тухайн үед би бас санаачлалцаад явж байсан. Энэ одоо хуулийн төслийг Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцэн шийдэх гэж байна аа. Энэ бас чухал асуудал аа. Тэгээд и-спортоо бас дэмжээд дэлхийд бас Монголын нэр алдрыг гаргаж байгаа энэ залуучуудаа дэмжээд энэ хуулийг бас баталчих нь зүйтэй гэж бодож байгаа.

Цаашдаа энэ үндэсний спорт, үндэсний бөх, морь морин уралдаан, морины спорт мөн цаашлаад сурын спорт гээд энэ сур харваа энэ бүгддээ бас ямархуу байдлаар дэмжлэг үзүүлэх юм. Энийг бас бидний бас нэг бодох асуудал болсон байх аа гэж бодож байна аа.

Батчимэг гишүүн та үг хэлэх байсан уу, үгүй юу? орхичих уу тиймээ. Тэгвэл үдээс хойш 14 цагаас санал хураалтаа явуулъя. Одоо бол энэ чуулганы хуралдааны танхимд санал хураах боломж алга байна. Гишүүд ирцдээ орчхоод ажлаа хийж байна гэж бас битгий ингэж хандаач ээ. Саналаа өгч ажлаа хиймээр байна аа. Ирцдээ орсныг ажил хийсэнд тооцохгүй шүү. Цаашдаа санал хураалтдаа оролцоод дэмжиж байгаа бол өөрийн биеэр, дэмжихгүй байгаа бол өөрийн биеэрээ саналаа өгдөг баймаар байна. Ирцдээ орчхоод саналаа өгөхгүй алга болж ажил хийдүүлэхээ болимоор байна.

Тийм болохоор 14 цагаас нэлээд олон хуулиудын санал хураалтуудыг явуулна. Түрүүн бас хэлсэн. Нөгөө гадаад зээлийн ашиглалтын санал хураалтыг бас 14 цагаас явуулна аа. Ирэх 4 дэх өдөр биш. Яагаад гэвэл яаралтай чухал асуудлууд байгаа учраас. Тийм болохоор 14 цагт ажлаа зохицуулаад АН-ын бүлгийн гишүүд бас нэг 30 минут, нэг цагийн хугацаатай бас Үндэсний бодлогын хорооныхоо хурлаа нэг түр завсарлаад байдаг юм уу бас нэг санал хураалтад нэг түр оролцоод өгөөч ээ гэж бас урьж байна, хүсэж байна.

14 цагаас чуулганы хуралдаан үдээс хойших хуралдаан эхэлнэ. Үлдсэн асуудлуудыг санал хураалтуудын дараа хэлэлцэж өнөөдөртөө багтаж дуусгана аа. Тийм болохоор 14 цаг хүртэл чуулганы хуралдааныг түр завсарлуулж байна аа.

ЗАВСАРЛАГА

С.Бямбацогт: Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдаанаа эхлүүлье. Энэ чинь өглөөнийхөө ирцээр явна тийм үү? Өглөөний ирцээр явна. Ирцэд 115 гишүүн орсон байна. 91.3 хувийн ирц бүрдсэн байна. Чуулганы танхимд гишүүдийг урьж байна аа. Гишүүдийг чуулганы хуралдааны танхимд урьж байна. Санал хураалтаар үдээс хойших чуулган эхэлнэ ээ.

Гадаад зээлийн ашиглалтын тухай хууль Улсын Их Хурлын 21 гишүүн өргөн мэдүүлсэн байгаа. Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай анхдагч хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Алтаншагай, Алдаржавхлан, Анар, Бат-Амгалан, Баярбаатар, Болормаа, Ганхуяг, Ганхүлэг, Жангабыл, Зулпхар, Идэрбат, Мөнхбат, Мөнхтулга, Номин, Отгонбаяр, Пунсалмаа, Рэгдэл, Сайнзориг, Туваан, Тулга, Уянга, Энхтуяа нарын 21 гишүүн өргөн мэдүүлсэн байгаа.

Хууль санаачилсан гишүүдийг танхимдаа урьж байна аа. Сая нэр дурдсан гишүүдийг. Санаачилсан хуулийн санал хураалт явах гээд байгаа. За ирцдээ орсон гишүүдийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урьж байна аа.

Улсын Их Хурлын гишүүн Алтангэрэл, Хосбаяр нарын урилгаар Өвөрхангай аймгийн алдарт эхийн одонтой ээжүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Манай Алтангэрэл гишүүн, Хосбаяр гишүүд өөрсдөө дунд нь ээж болчихсон зогсож байна шүү дээ. Тэгээд та бүхэндээ Монгол Улсынхаа Их Хурлын нийт гишүүдийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё оо.

Одоо байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж мөн аль нэг нам эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн үг хэлж болно оо. Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа.

Гишүүд эхлээд ирцийн санал хураалт явуулчихъя тийм. Ирцээ бүртгүүлэх газар биш бид одоо тийм үү саналаа өгч ажлаа хийх газар шүү Их Хурал бол. Тийм болохоор ирцийн санал. Ирцээ цаашдаа ер нь Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд ирц бүрдүүлснээр ажлаа хийж байгаад тооцохгүй, санал өгснөөр ажлаа хийж байгаад тооцдог. Дэмжих, дэмжихгүй нь чухал биш. Ийм одоо бас дэгийн өөрчлөлт орно оо. Тийм болохоор бүртгэлийн санал хураалт. Санал хураалтад бэлдье. Бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

62 гишүүн ирцдээ орсон байна. Ирцэндээ ороогүй 52 гишүүнийг чуулганы танхимдаа хүрэлцэн ирж ирцэндээ орж, санал хураалтдаа оролцохыг урьж байна аа.

Зарчмын зөрүүтэй 15 санал байгаа. Гишүүд санал хураалтад бэлдье.

Гадаад зээлийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёол.

Төсвийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилт гэсэн агуулгатай зүйлийн гарчиг тус зүйлийн өмнө нийтлэг үндэслэл гэсэн агуулгатай 1 дүгээр бүлгийн нэр мөн зүйлийн аюулгүй байдлыг хангах гэсний дараа бодлогын хүрээнд хэрэгжих гэж тус тус нэмж, мөн зүйлийн санхүүжилтийн ашиглалтыг гэснийг гадаад зээлийн ашиглалтыг гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батболд, Батсүмбэрэл, Баярмаа, Даваасүрэн, Заяабал, Мэндсайхан, Пунсалмаа, Сайнзориг, Хосбаяр, Энхтуяа. Цаашид ажлын хэсэг гэх.

За санал хураалт. Төхөөрөмж ажиллаагүй гишүүд дэмжсэн санал. Хэрлэн гишүүн, Эрдэнэбат гишүүн, Номин гишүүн, Саранчулуун гишүүн, Баасанжаргал гишүүн, Болормаа гишүүн, Э.Болормаа, Бум-Очир гишүүн, Цогтбаатар гишүүн, Дамдины Цогтбаатар гишүүн, Энхтүвшин гишүүн, Энхнасан гишүүн, Хосбаяр

гишүүн, Батчимэг гишүүн, Баярмаа гишүүн, Баатархүү гишүүдийг дэмжсэнд тооцъё оо.

Дараагийн санал хураалт. 2 хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр 14 мега төслийн жагсаалтад тусгагдсан Импортыг орлох нийгэм, эдийн засгийн ач холбогдол үр ашиг бүхий үйл ажиллагааны орлогоороо зардлаа нөхөх боломжтой. Нийслэл Улаанбаатар хотын тулгамдаж буй асуудал болох хүрээлэн буй орчны бохирдол, авто замын түгжрэлийг бууруулах нь бууруулах энэ хуульд заасан гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Дашцэрэнгийн Энхтүвшин. За санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүнээс 69 гишүүн дэмжсэн 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Хуулийн төслийн 2 дугаар зүйлд хуулийн үйлчлэх хүрээ гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн холбогдсон харилцаа гэсний дараа болон дараа болон гадаад зээлийн эх үүсвэрийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагатай холбогдсон харилцаа гэж тус тус нэмж, мөн зүйлийн зээллэгийн санхүүжилтийн ашиглалт гэснийг зээллэгийн ашиглалт гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 72 гишүүн буюу 63.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Бейсен гишүүнийг дэмжсэнээр авъя гэж байна. Дараагийн горимын санал байхгүй ээ.

4.Хуулийн төслийн 3 дугаар зүйлийг 2.2 дахь хэсэг болгож мөн зүйлийн Сэлбэ дэд төвд түшиглэсэн гэр хорооллыг орон сууц төсөл гэсэн агуулгатай 3.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 66 гишүүн буюу 57.9 хувийн саналаар. Биш энэ чинь өөр юм гараад ирсэн байна шүү дээ.

114 гишүүнээс 48 гишүүн буюу 42.1 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

5.Хуулийн төслийн 3 дугаар зүйл доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх:

2.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн нэрийг өөрчлөх, шинэ төсөл нэмэхийг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг. Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 78 гишүүн буюу 68.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

6.Хуулийн төслийн 4 дүгээр зүйлийг 3 дугаар зүйл болгож тус зүйлд Гадаад зээллэгийн ашиглалтын зардал гэсэн агуулгатай зүйлийн гарчиг мөн зүйлийн өмнө гадаад зээллэгийн ашиглалт нэгдсэн төсөв хоорондын хамаарал гэсэн агуулгатай 2 дугаар бүлгийн нэр тус тус нэмж, мөн зүйлийн нийт зарлага гэснийг нийт зарлагын дээд хэмжээ гэж, санхүүжилтийн ашиглалтын зардал түүний зардлын өсөлтөөр

гэснийг тухайн жилийн ашиглалтын зардлын өсөлтөөр гэж тус тус өөрчилж, тухайн жилийн гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 72 гишүүн буюу 63.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Яг үнэндээ 72 гишүүн ч оролцоогүй байгаа л даа. Ирцэндээ ороод нэлээн олон гишүүд тэгээд дэмжээгүй л гараад яваад байгаа. 114 гишүүн оролцоогүй.

8.Хуулийн төслийн 6 дугаар зүйлийг 3.2 дахь хэсэг болгож мөн зүйлийн гадаад зээлийн санхүүжилтийн гэснийг гадаад зээллэгийн гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

7.Хуулийн төслийн 5 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

9.Хуулийн төслийн 7 дугаар зүйлийг 3.3 дахь хэсэг болгож мөн зүйлийн энэ хуулийн 3.3-д заасан гэснийг гадаад зээлийн эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа гэж өөрчилж, мөн зүйлийн хэсэг гэсний дараа болон энэ хуулийн 3.1-д заасан хязгаар гэж нэмж санхүүжилтийн гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 62.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10.Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн дугаарыг 4 гэж өөрчилж, мөн зүйлд гадаад зээллэгийн ашиглалтын ил тод байдал хяналт гэсэн агуулгатай зүйлийн гарчиг, мөн зүйлийн өмнөх хяналт ил тод байдал гэсэн агуулгатай 3 дугаар бүлгийн нэр, мөн зүйлийн тухайн жилийн гэсний дараа нэгдсэн гэж тус тус нэмж, хагас жил тутам гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 69 гишүүн буюу 60.5 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

11.Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийг 4.2 дахь хэсэг болгож мөн зүйлийн төслийн ашиглалттай гэснийг зээллэгийн ашиглалттай гэж, журмын гэснийг хууль тогтоомжийн гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 74 гишүүн буюу 64.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

12.Хуулийн төсөл доор дурдсан агуулгатай бүлэг нэмэх.

4 дүгээр бүлэг, бусад зүйл 5 дугаар зүйл. Хуулийг дагаж мөрдөх журам.

5.1 Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулиар батлагдсан гадаад зээл тусламжаас санхүүжих зардлаас энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээлийн ашиглалтад 2026 оны төсвийн жилд санхүүжүүлсэн зардлыг энэ хуулийн 3.1, 3.2-т заасан үйлчлэлд хамааруулна.

5.2.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хуулийн 10.2-т заасан Засгийн газрын авч ашиглах гадаад зээлийн дээд хэмжээ нь энэ хуулийн 2.2.1, 2.2.2-т заасан төслийн гадаад зээлийн ашиглалтын зардлаар нэмэгдэж болно.

5.3.Энэ хуулийн 2.2-т заасан төслийн гадаад зээлийн ашиглалт бүрэн дуусах хүртэлх хугацаанд энэ хуулийг дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 62.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зочин танилцуулъя аа. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын ЕБС-ийн 8-ын “Г” ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Манай Сэлэнгэ аймгийн Ундрам гишүүн олон гишүүд энд сууж байгаа. Эрдэнэболд гишүүн, Туваан, тэгээд Энхбаяр, Ж.Энхбаяр гишүүн, Дамдинням гишүүн, Лүндэг гишүүн, Батжаргал гишүүн, Батбаяр, Даваагийн Батбаяр гишүүн. За Баярлалаа.

13.Хуулийн төсөлд шинээр нэмэх 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмэх.

5.4 дунд хугацаанд олон улсын банк санхүүгийн байгууллага болон хөгжлийн түнш орнуудын санхүүжилтээр хэрэгжих төслийн орлогоороо хөрөнгө оруулалтын зардлаа бүрэн нөхөх боломжтой. Эдийн засгийн үр ашиг бүхий хөгжлийн төсөл арга хэмжээг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлж болох бөгөөд төслүүдийг хэрэгжүүлэхэд Засгийн газар өрийн баталгаа гаргаж болно оо. Энэ бас нэлээн асуудалтай заалт уу, үгүй юү? За ажлын хэсгийн ахлагч Алдаржавхлан гишүүн.

Ж.Алдаржавхлан: Гүйцээн боловсрох чиглэл авч байгаа. Ярилцах шаардлага байгаа бас тийм. Ажлын хэсэг дээр.

С.Бямбацогт: Харин тийм байх шиг байна. Хөгжлийн банкаар дамжуулан санхүүжүүлэх өрийн баталгаа гаргах гээд.

Ж.Алдаржавхлан: Тийм, чиглэл авчихъя.

С.Бямбацогт: За энийг гүйцээн боловсруулъя. Бас хууль хоорондын зөрчил байх шиг байна шүү. Энийг хойшлуулъя энэ санал хураалтыг.

14 хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёололтой уялдуулан төслийн зүйл хэсэг заалтын дугаарыг болон тэдгээрийн эшлэлийг нийцүүлэн өөрчлүүлэх, нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 71 гишүүн буюу 62.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

15. Найруулгын санал:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн зориулан эрх зүйн таатай орчныг гэснийг зориулсан эрх зүйн орчныг гэж, зорилго гэснийг зорилт гэж, 2 дугаар зүйлийн энэ хуулиар гадаад зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан төслийн гэснийг энэ хуулийн 2.2-т заасан гадаад зээлийн эх үүсвэрээс хэрэгжүүлэх төслийн гэж, зохицуулах ба энд зааснаас гэснийг энэ хуулиар зохицуулах ба энэ хуульд зааснаас гэж, төслийн 4 дүгээр зүйлийн үл хамаарна гэснийг үл хамаарахгүй гэж, төслийн 7 дугаар зүйлийн санхүүжих зардал гэснийг санхүүжүүлэх зарлага гэж, нөхцөлд гэснийг тохиолдолд гэж тус тус өөрчилж төслийн 4 дүгээр зүйлийн төслийн гэсний өмнөх болон 6 дугаар зүйлийн нийт гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ, санал хураалт хэдхэн одоо маш цөөхөн санал хураалт байгаа шүү Жаргалан гишүүн ээ, Батчимэг гишүүн ээ түр сууж байхгүй юу. Тун удахгүй.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 58.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа. Гадаад зээллэгийн ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудал 6.

Дарга юу дэгтэй Ганбат гишүүн ээ. Нөгөө дэгээр та нөгөө урьдчилаад үгээ өгсөн байх ёстой. Өгсөн байсан юм уу Ганбат гишүүн. Үгээ аваагүй байна аа. Тийм дэг байхгүй.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулна аа.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Санал хураалтад бэлтгэе ээ. Дэгийн хуулиа та үз л дээ. Санал хураалтад бэлдсэн гишүүн 53 байна, бэлдээгүй 61 гишүүн байна. Тэгээд дутуу. Санал хураалтдаа бэлдье. Хуруугаа хийгээд ирцэндээ, санал хураалтдаа бэлдчихээрэй гишүүд ээ. Санал хураалт.

1. Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 67 гишүүн буюу 58.1 хувийн саналаар Батболд гишүүн дэмжсэнд тооцъё, Пүрэвдорж гишүүн дэмжсэнд тооцъё, Цэнгүүн гишүүн дэмжсэнд тооцъё. Ингээд энэ гишүүдийг нэмээрэй. 70 гишүүн болж байна. Тогтоолын төслийг баталлаа.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал илэрхийлье.

Дараагийн асуудалдаа оръё.

Долоо.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлэлцэх эсэх

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн санал хураалтыг явуулна аа.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдээд гишүүд хуруугаа уншуулаарай. Санал хураалт.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 68 гишүүн буюу 59.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал байна. Хэлэлцэхийг дэмжихээр хурааж байгаа шүү. Хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн томъёоллоор. За яах юм цаашаа явчихъя.

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг саяын санал хураалт 114 гишүүнээс 57 буюу 50 хувийн саналаар дэмжигдсэнгүй. Энэ Гаалийн албан татварын тухай хуулийг хэлэлцэхгүй ээ гэсэн үг шүү. Үгүй.

Уншсан саналын томъёолол нь Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураасан сая. Үгүй үгүй, будилаагүй будилаагүй. За яах юм тэгээд горимын санал гарах юм уу? Батлут гишүүн горимын санал.

Д.Батлут: Би дэмжиж саяын асуудал дээр дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж ажилласангүй. Тэгэхээр саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөөд дахин санал хураалгаж өгнө үү?

С.Бямбацогт: Үгүй үгүй. Би тайлбар хэлэхдээ яасан юм. Тэгвэл Батлут гишүүний горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалт явуулъя аа.

Батлут гишүүний горимын санал дэмжигдлээ. Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 70 гишүүн буюу 61.4 хувийн саналаар саяын санал дэмжигдлээ.

Санал хураалтыг дахин явуулъя.

2.Гаалийн тариф, гаалийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая. Би томъёоллоо маш тодорхой уншсан. Төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураасан сая. Дэгийн хуулиараа Байнгын хорооны саналаар санал хураадаггүй ээ. Хэлэлцэх эсэх үед тийм үү төслийг хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих, дэмжихгүй санал хураадаг аа. Анхны хэлэлцүүлгийн үед Байнгын хорооны саналаар санал хураадаг. Тийм учраас би дахин дахин хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураая гэж би 2 удаа хураалгалаа шүү дээ.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.12 үг хэлж дууссаны дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна тийм. Үгүй ээ харин би 2 дахь дээрээ будилуулсангүй шүү дээ. Эхнийх дээр бол нөгөө доод талд нь хаалтан дотор хийчихсэн байсан шүү дээ. За хэд ээ. 36.14 санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно оо. Тогтоол батлагдсанд тооцлоо.

Танилцуулга хийчихье. Улсын Их Хурлын гишүүн Загджавын Мэндсайханы урилгаар Ховд аймгийн иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхний ажилд нь амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг Улсын Их Хурлынхаа нийт гишүүдийн нэрийн өмнөөс хүргэе ээ.

3.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ бас дэмжигдсэнгүй. 114 гишүүнээс 57 гишүүн буюу 50.0 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй ээ.

Энэ Төсвийн байнгын хороон дээр энэ 2 санал хоёулаа унасан юм байна лээ. Мэргэжлийн байнгын хороо нь энийг шаардлагагүй гэж үзсэн юм байна лээ тийм. Тэгээд л тэрүүгээрээ л явж байна шүү дээ тийм. Үгүй дэгийнхээ хууль үзээдхээрэй та. Хэлэлцэх эсэх анхны хэлэлцүүлэг хоёр өөрөө тийм. Та бүхэн анхны хэлэлцүүлгүүд Байнгын хорооны санал, дүгнэлтийг танилцуулдаг. Байнгын хорооны санал дүгнэлтээр саналаар санал хураадаг.

36.14.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол батлагдсанд тооцно гэж заасны дагуу буцаалаа.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

Дараагийн асуудалдаа оръё.

**“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын
тогтоолын төсөл**

Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 40 гишүүн 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Ардын намын бүлэг завсарлага авсан. Дараагийн асуудалдаа орсон. Ингээд завсарлагын хугацаа дуусаад нэлээн удчихсан байгаа байх. Хянан шалгах түр хороо байгуулах Улсын Их Хурлын тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ ээ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 5 өдрийн ажлын 5 өдрийн завсарлага авсан бөгөөд завсарлагын хугацааг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ажлын 3 өдрөөр сунгасан. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулан Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга үг хэлэх үү та? Үг хэлэхгүй юу?

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа. Гишүүд санал хураалтад бэлдье. Санал хураалтад бэлдье. Санал хураалтдаа бэлдсэн үү гишүүд. Санал хураалт явуулах уу, гишүүд бэлэн үү. Дараад нь. За санал хураалт.

Хянан шалгах түр хороо байгуулах тухай Улсын Их Хурлын тогтоолыг тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 114 гишүүн оролцсоноос 43 гишүүн буюу 37.7 хувийн саналаар энэ санал дэмжигдсэнгүй. Энэ буцаагдах уу бас тиймээ. Дэмжигдээгүй учраас түрүүн Хянан шалгах түр хороо байгуулах тогтоол батлагдаагүйд тооцлоо.

Дараагийн асуудалдаа оръё.

14.47 цаг

Баталсан тогтоолынн эцсийн найруулга сонсох

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1.3-д Улсын Их Хурал Энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу тогтоолын эцсийн найруулгыг холбогдох байнгын хороо бэлтгэж, Улсын Их Хуралд танилцахад бэлэн болсон байна аа.

1.Монгол Улсын ҮХЦ-ийн 2025 оны 12 дугаар дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байгаа эсэхийг байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Монгол Улсын ҮХЦ-ийн 2026 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Тогтоолд нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Одоо дахиад асуудал байгаа шүү. Байнгын хорооны бүрэлдэхүүний асуудлаар гишүүдээ түр хүлээж байгаарай. Батсуурь гишүүн ээ, Баярмаа гишүүн ээ, Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудал байгаа. Эрхэм гишүүдэд нэг асуудал үлдсэн. Энэ асуудлаа хэлэлцээд өнөөдрийн чуулганы хуралдаан дуусна аа тийм. Гишүүдийг чуулганы танхимдаа. За гишүүд түр хүлээж байхыг хүсье.

Байнгын хорооны бүрэлдэхүүний асуудал удахгүй ээ ерөөсөө. Бямбадуламд аваачаад өгчих. Санал хураалттай.

Монгол Улсын Их Хурлын чуулган дараагийн асуудалдаа оръё.

Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22.1.3-д Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах гэж заасны дагуу зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя. Нөгөө Хүн намынхан орсон уу?

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Зарим байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас Тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Сүрэнжавын Лүндэг, Загджавын Мэндсайхан, Баттөмөрийн Энхбаяр нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбатыг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Батмөнхийн Батцэцэг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан нарыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Цэндийн Сандаг-Очир, Цагаанхүүгийн Идэрбат, Чинбатын Номин, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан, Загджавын Мэндсайхан нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Сайнбуянгийн Амарсайхан, Энхбаярын Батшугар нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Жуковын Алдаржавхлан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Батын Батбаатар, Жуковын Алдаржавхлан, Энхбаярын Батшугар нарыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Батмөнхийн Батцэцэгийг Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбатыг Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны, Болдын Жавхлан, Чинбатын Ундрам, Баттөмөрийн Энхбаяр, Баттогтохын Чойжилсүрэн

нарыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны, Хассуурийн Ганхуяг, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Чинбатын Ундрам нарыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны, Жигжидсүрэнгийн Чинбүрэн, Сүрэнжавын Лүндэг нарыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны, Цагаанхүүгийн Идэрбатыг Улсын Их Хурлын Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны, Загджавын Мэндсайханыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Мөн энэ дээр бас Хүн намын зөвлөлөөс бас хүсэлт ирүүлсэн байгаа. Энэ дээр Пүрэвжавын Ганзоригийг Эдийн засгийн байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлж, Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээр оруулах, Найдалааг Эдийн засгийн байнгын хорооны биш Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны гишүүнээс чөлөөлөх орж ирж байгаа шүү бас.

Ингээд энэ тогтоолыг 2026 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын төсөлтэй холбогдуулаад тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя. Тийм тэрний дагуу хийж байгаа. Санал хураалтад бэлдээд энэ чинь ирц жоохон юу яачихлаа тиймээ. Гишүүд ээ санал хураалт явах гэж байна. Чуулганы танхимдаа хүрэлцэн ирэхийг урья аа. Ганцхан асуудал байгаа. Энэ асуудлаа хэлэлцээд дуусгачихъя. Ганцхан санал хураалт. Заяабал гишүүн ээ чуулганы танхимдаа. Сайд нар нэг байнгын хороонд орж байгаа. Байнгын хорооны дарга байсан, гишүүн байсан, сайд болсон сайд нарыг нэг байнгын хороонд оруулж байгаа.

Зочин танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжингийн урилгаар Төв аймгийн Борнуур сумын иргэд Улсын Их Хурлын үйл ажиллагаа Төрийн ордонтой танилцаж байна аа. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс амьдралд нь аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе өө. За энд би. Санал хураалтад бэлдэх үү? Гишүүдийн ирц ямархуу байна? Наана чинь алдаатай болчихсон гээд байх юм. Тийм Борнуур. Төв аймгийн Борнуур сумын иргэд Төрийн ордны үйл ажиллагаатай танилцаж байна.

Бүртгэлийн санал хураалт. Гадуур үүдэнд байгаа, коридорт байгаа гишүүдийг чуулганы танхимдаа урьж байна. Бүртгэлийн санал хураалт, ирц бүртгэлийн санал хураалт.

33 гишүүн гэж гарч байна шүү дээ нөхөд өө. Одоо ирцэндээ орчхоод ингээд гараад явчихдаг. Санал хураалтдаа ингээд оролцдоггүй, ажлаа хийдэггүй. Уул нь санал хураалтдаа оролцоод дэмжих, дэмжихгүй саналаа өгч л байх нь чухал л даа бидний үндсэн үүрэг бол. Тэгээд үүнээс болоод Улсын Их Хурлын үйл ажиллагаа гацдаг. Тэгээд Их Хурал ажлаа хийж чадахгүй байна. Ажлаа хийдэггүй гишүүд гээд бас ард түмэн бухимддаг ийм л болчихоод байгаа шүү дээ.

Батжаргал гишүүн бүлгийн дарга МАН-ын бүлгийн дарга.

Ж.Батжаргал: Гишүүдийн ирцэнд орсон гишүүдийн оролцоо бага байгаа учраас санал хураалтыг хойшлуулж өгөх хүсэлт тавьж байна аа.

С.Бямбацогт: За тэгвэл өнөөдрийн чуулганы хуралдаан ингээд ирц хүрэхгүй санал хураалтдаа гишүүд оролцохгүй байгаагаас асуудлаа шийдэх боломжгүй болсон. Тийм болохоор ирэх 7 хоногийн Пүрэв гарагийн чуулган хүртэл энэ санал хураалтыг хойшлууллаа.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Чуулганы хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ их баярлалаа.

14.52 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*